

СОНГУУЛИЙН БОЛОВСРОЛ



СЭТГҮҮЛЭГ 2024 / 01



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
СОНГУУЛИЙН
БОЛОВСРОЛ



Монгол Улсын Их Хурлын
СОНГУУЛЬ

2024

САНАЛ АВАХ ӨДӨР

06.28



www.m-election.mn

YouTube GEC Mongolia

Монгол Улсын Сонгуулийн
ерөнхий хороо





РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

ЭРХЛЭГЧ

Д.Бат-Эрдэнэ

Тамгын газрын дарга

ХАРИУЦЛАГАТАЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Г.Ариунболд

Мэдээлэл, судалгаа, сургалтын төвийн мэргэжилтэн

ЗӨВЛӨХ

Ж.Амарсанаа

Академич, хууль зүйн шинжлэх ухааны доктор

ГИШҮҮД

П.Алтанчимэг

Мэдээллийн технологийн төвийн ахлах референт

Ш.Сүхбаатар

Хууль зүйн ухааны доктор, судлаач

С.Оюунтуяа

"Сонгогчдын боловсрол төв" ТББ-ын гүйцэтгэх захирал

Ч.Сайнсанаа

Чимид сангийн тэргүүн

З.Бадмаараг

Сэтгүүлч

С.Уянга

"Сонгуулийн боловсрол" клубийн удирдах зөвлөлийн дарга

@Бүтээлийн зохиогчийн эрх хуулиар хамгаалагдсан тул олшруулахыг хориглоно.

АГУУЛГА

4

01.ХУУЛЬ ТОГТООМЖ

- Улсын их хурлын 2024 оны ээлжит сонгуулийн тойрог, мандатын тоо, нутаг дэвсгэр, төвийг тогтоолоо

7

02. ДУГААРЫН ЗОЧИН

- Д.Даваа-Очир: Сонгуулийн үеийн зөрчлийг есөн байгууллагын эрх бүхий албан тушаалтан шалган шийдвэрлэнэ

12

03. ЦАГ ХУГАЦААНЫ ХУВААРЬ

- Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн үйл ажиллагааг зохион байгуулах цаг хугацааны хуваарь

22

04.СУДАЛГАА

- Улс төрийн санхүүжилт, сонгуулийн шинэчлэлийн асуудлууд

28

05.ГАДААД УЛС ДАХЬ СОНГОГЧ

- Гадаад улсад байгаа сонгогчдын саналыг 2024 оны 06 дугаар сарын 20, 21, 22, 23 -ны өдрүүдэд авна

30

06.НИЙТЛЭЛ

- Улс төрийн намын тухай хуулийн шинэчлэл

39

07.СОНГУУЛИЙН БОЛОВСРОЛД

- Азийн сонгуулийн байгууллагуудын форум AESF VI

41

08.ХАРИУЦЛАГАТАЙ СОНГОГЧ

- Сонгуулийн үеэр түгээдэг хуурамч мэдээллийг таних нь
- Сургалтын төгсгөлд нийт сурагчдын сонгуулийн тухай ойлголт үндсээрээ өөрчлөгдсөн

48

09.СОНГУУЛИЙН ХУУЛИАС

- Сонгуулийн зөрчил шалган шийдвэрлэх харьяалал

53

10.СОНГУУЛЬ ДЭЛХИЙ ДАХИНД

- Дэлхийн улс орнуудын 2024 онд зохион байгуулах сонгуулийн хуанли



УЛСЫН ИХ ХУРЛЫН 2024 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛИЙН ТОЙРОГ, МАНДАТЫН ТОО, НУТАГ ДЭВСГЭР, ТӨВИЙГ ТОГТООЛОО



Улсын Их Хурлын чуулганы (2023.12.21) нэгдсэн хуралдаанаар 2024 онд болох Улсын Их Хурлын ээлжит сонгуультай холбоотой тогтоолын төслүүдийг хэлэлцлээ. “Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн тойрог байгуулах, тойргийн мандатын тоо, дугаар, нутаг дэвсгэр, төвийг тогтоох тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэв. Тогтоолын төслийг бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын зорилго, зорилтыг хангах, аймаг, дүүргийн хүн амын тоо, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хуваарь, газар нутгийн хэмжээ, байршил, Улсын Их Хуралд суудалтай болон улс төрийн бусад намуудтай зөвшилцсөн байдал, сонгуулийн тойрогт хамаарах засаг захиргааны нэгж нь нутаг дэвсгэрийн хувьд нэгдмэл, хилийн цэсийн хувьд зэргэлдээ байх зэрэг хуулийн

зохицуулалт, Улсын бүртгэлийн ерөнхий газраас ирүүлсэн Монгол Улсын хүн ам, сонгуулийн насны иргэдийн тоо зэргийг үндэслэн боловсруулсан талаар тодорхой дурдав.

Төсөлд, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тойргийг Улсын Их Хурлын 2001 оны 57-р тогтоолоор баталсан “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-д нийцүүлэн 5 бүсэд хамаарах нийт 13 тойрогтой байхаар тусгасан байна. Үүнд:

Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын хүрээнд Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн 2, 3 дугаар тойрогт баруун бүсийн Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан, Увс, Ховд аймгийг, 1, 4 дүгээр тойрогт хангайн бүсийн Архангай, Баянхонгор, Булган, Орхон, Өвөрхангай,

Хөвсгөл аймгийг, 5, 7 дугаар тойрогт төвийн бүсийн Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Дундговь, Өмнөговь, Сэлэнгэ, Төв аймгийг, 6 дугаар тойрогт зүүн бүсийн Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймгийг, 8, 9, 10, 11, 12, 13 дугаар тойрогт Улаанбаатарын бүсийн Баянзүрх, Баянгол, Сүхбаатар, Чингэлтэй, Сонгинохайрхан, Хан-Уул, Багануур, Багахангай, Налайх дүүргийг хамруулан тогтоолоо.Эдгээр тойргуудыг тогтоохдоо 2019, 2023 онд Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг хэрэгжүүлэх, хот хөдөөгийн хөгжлийн тэнцвэрийг хангах, төвлөрлийг бууруулах, эдийн засгийн нөөцийг зохистой хуваарилах, хөгжлийн төвүүдийг бий болгох, үндэсний эв нэгдэл, тусгаар тогтнол, аюулгүй байдлын баталгааг дээшлүүлэх зорилтуудыг үндэслэл болгосон хэмээн Төрийн байгуулалтын байнгын хорооны

дарга Н.Энхболд тэмдэглэв.

Төрийн байгуулалтын байнгын хорооны санал дүгнэлтийн дагуу, “Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн тойрог байгуулах, тойргийн мандатын тоо, дугаар нутаг дэвсгэр, төвийг тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураахад чуулганы нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн 72.3 хувь нь дэмжив. Ингээд Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар тогтоолын эцсийн найруулгыг уншиж сонсгосноор уг тогтоол батлагдлаа.



СОНГУУЛЬ 2024



VI.28 07⁰⁰ – 22⁰⁰

ГАДААД УЛС ДАХЬ СОНГУУЛЬ

VI.20, 21, 22, 23

07⁰⁰ – 22⁰⁰



Д.Даваа-Очир:

СОНГУУЛИЙН ҮЕИЙН ЗӨРЧЛИЙГ ЕСӨН БАЙГУУЛЛАГЫН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН ШАЛГАН ШИЙДВЭРЛЭНЭ



УИХ-ын сонгуулийн бэлтгэл ажил болон сонгуулийн хуулийн зөрчилд хэрхэн хяналт тавьж шийдвэрлэх талаар Сонгуулийн ерөнхий хорооны Нарийн бичгийн дарга Д.Даваа-Очиртой ярилцлаа.

Ээлжит холбоотой ерөнхийдөө боллоо. Бэлтгэл ажил хэрхэн хангаж байна вэ?

2024 оны УИХ-ын сонгуулийг холимог тогтолцоогоор явуулна. УИХ-ын 78 гишүүнийг олныг төлөөлөх, 48 гишүүнийг хувь тэнцүүлэн төлөөлөх аргаар сонгохоор болсон. Өөрөөр хэлбэл, 78 гишүүнийг сонгуулийн томсгосон тойргоос олныг төлөөлөх мажоритар аргаар сонгоно. Сонгуулийн хуулийн

“

Сонгуулийн нэг тойрогт хоёр ба хэд хэдэн аймаг, дүүрэг багтаж байвал аль олон сонгогчтой аймаг, дүүргийн сонгуулийн хороо нь ТУХАЙН ТОЙРОГ ДАХЬ СОНГУУЛИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН АЖЛЫГ ХАРИУЦАХААР заасан

дагуу бүсчилсэн байдлаар 13 тойрогтойгоор байгуулах шийдвэрийг УИХ гаргасан. Зургаадугаар сарын 28-нд санал хураалт явагдана. Тухайлбал, УИХ-ын ээлжит сонгуулийн жилийн хоёрдугаар сарын 01-ний өдрөөс өмнө сонгуулийн тойргийг байгуулна. Сонгуулийн нэг тойрогт хоёр ба хэд хэдэн аймаг, дүүрэг багтаж байвал аль олон сонгогчтой аймаг, дүүргийн сонгуулийн хороо нь тухайн тойрог дахь сонгуулийн зохион байгуулалтын ажлыг хариуцахаар заасан. Сонгогчдын санал авч, тоолох зорилгоор сум, дүүргийн ИТХ сонгуулийн хэсгийг ээлжит сонгуулийн жилийн гуравдугаар сарын 01-ний өдрөөс өмнө байгуулж, хэсгийн нутаг дэвсгэрийг зарладаг. Энэ мэтээр цаг хугацааны хуваарийг гарган хууль журмын дагуу ажиллаж байна.

Энэ оны нэгдүгээр сарын 1-нээс эхлээд нам, эвсэл нэр дэвшигчидтэй холбоотой багагүй хязгаарлалтууд үйлчилж эхэлсэн. Энэ талаар тодорхой мэдээлэл өгвөл?

Сонгуулийн жил эхэлсэнтэй холбоотойгоор хуульд зааснаар шинэ оны эхнээс зарим төрлийн хязгаарлалтууд хэрэгжиж эхэллээ. Хүн, хуулийн этгээд ээлжит сонгуулийн жил эхэлснээс хойш санал авах өдрийг дуустал, эсвэл нөхөн болон ээлжит бус сонгууль товлон зарласан шийдвэр гарснаас хойш санал авах өдрийг дуустал сонгогчдын саналыг татах зорилгоор бараа, эд зүйл хөнгөлөлттэй үнээр худалдсан, аливаа үйлчилгээг хөнгөлөлттэй болон төлбөргүйгээр үзүүлэхийг хориглодог. Мөн нийтийг хамарсан биеийн тамирын уралдаан, тэмцээн, баяр наадам, урлагийн тоглолт, хүлээн авалт, дайллаа, цайллаа, хонжворт сугалаа зохион байгуулах, сонгогчдыг гадаад, дотоодод аялал зохион байгуулан оролцуулах, амралт, сувилалд амрааж, сувилуулж болохгүй. Түүнчлэн ирээдүйд өөрийн болон бусдын хөрөнгөөр мөнгө, эд бараа өгөхөөр гэрээ байгуулсан, хэлцэл хийсэн, хишиг, хувь, хувьцаа өгөх, ажлын байранд зуучлах, ажилд оруулах зэргээр давуу байдал олгосон, амлалт өгөх, сонгуульд оролцохоос татгалзах болон сонгуулийн хууль тогтоомж зөрчихийг уриалсан агуулга бүхий сурталчилгаа явуулах нь хуулиар хориотой. Харилцаа холбоо болон хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим орчин ашиглан улс төрийн чансаа тогтоох зорилго бүхий аливаа хэлбэрийн шалгаруулалт, санал асуулга зохион байгуулсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол Зөрчлийн тухай хуулиар торгох заалттай.

Мөн сонгуулийн сурталчилгаа явуулах эрх бүхий этгээд нь хуульд зааснаас өөр арга, хэлбэрээр сонгуулийн сурталчилгаа явуулсан, зөвшөөрснөөс бусад хугацаанд сонгуулийн сурталчилгаа хийсэн. Нам, эвслийн нэр дэвшигч нь тухайн нам, эвслийн мөрийн хөтөлбөрөөс тусдаа мөрийн хөтөлбөр гаргаж ашигласан. Хандив өгөхийг хориглосон этгээдээс өгсөн хандивыг буцаан шилжүүлээгүй бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж торгуулийн арга хэмжээ авах зохицуулалттай.

Ер нь сонгуулийн үеэр хууль журам зөрчсөн бол гомдлыг хэрхэн богино хугацаанд шийдвэрлэх вэ. Хуулийн шинэчлэлтэй холбоотойгоор гомдлыг хянах, хариуцлага тооцох процесст өөрчлөлт орсон уу?

Сонгуулийн үеийн зөрчлийг Цагдаа, тагнуулын байгууллагын эрх бүх албан тушаалтан, Татвар, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар, Монголбанк, Улсын бүртгэл, нягтлан бодох, харилцаа холбооны улсын байцаагчид болон эрүүгийн хэргийн шүүх зэрэг есөн байгууллага шалгаж шийдвэрлэнэ. Үүнийг хуульд тус тусын эрх, үүргээр нь маш тодорхой заасан байдаг ба зөрчлийн талаас илүү хувийг цагдаагийн байгууллага шалгах бол улсын бүртгэл, татварын улсын байцаагч зөрчил шалган шийдвэрлэх зохицуулалт шинээр бий болсон. Өөрөөр хэлбэл, сонгуульд оролцоно гэдэг эргээд өндөр үүрэг, хариуцлагатай шүү гэдгийг тодорхой болгож байгаа юм.

Сонгуулийн хууль зөрчсөн тохиолдолд Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу эрх бүхий албан тушаалтан зөрчлийг шалган шийдвэрлэнэ. Тухайлбал, нэр дэвшигчийн нэр төр, алдар хүндийг гутаан доромжилсон худал мэдээллийг нийтэд тараасан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол торгоно.

Санал хураалтын дүн, сонгуулийн баримт бичгийг эрх бүхий байгууллагад хүргүүлэх, дамжуулахад саад учруулсан, сонгуулийн автоматжуулсан системийг ашиглан явуулж

байгаа мэдээллийн ажиллагаанд хуулиар эрх олгогдоогүй хүн, хуулийн этгээд хөндлөнгөөс оролцсон бол тагнуулын байгууллага шалгана. Татварын улсын байцаагч сонгуулийн зардлын дансыг бүртгүүлэх, зардлын дансанд мөнгөн хөрөнгийг төвлөрүүлж, зарцуулах талаар хуульд заасан журмыг зөрчсөн, хэмжээнээс хэтрүүлж нам, эвсэлд, эсвэл нэр дэвшигчид хандив өгсөн, тухайн намын нэгдэн орсон эвсэлд давхардуулан хандив өгсөн бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж торгоно. Мөнгөн бус хандив өгөх талаар хуулиар тогтоосон журмыг зөрчсөн бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж торгоно.

Монгол банкны хянан шалгагчийн хувьд сонгуулийн зардлын данс байршуулсан банк сонгуулийн санал авах ажиллагаа дууссан өдрөөс хойш 30 хоногийн дотор нам, эвсэл, нэр дэвшигчийн дансны гүйлгээний мэдээллийг төрийн аудитын дээд байгууллагад хүргүүлэх үүргээ биелүүлээгүй бол, улсын бүртгэлийн хяналтын улсын байцаагч хуульд зааснаас бусад тохиолдолд

сонгогчдын нэрийн жагсаалтыг олшруулсан, эсвэл тараасан бол шалгах юм. Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн улсын байцаагчийн хувьд нам, эвсэл, нэр дэвшигч нь сонгуулийн зардлын тайлангаа заасан хугацаанд төрийн

“

Монгол банкны хянан шалгагчийн хувьд сонгуулийн зардлын данс байршуулсан банк сонгуулийн санал авах ажиллагаа дууссан өдрөөс хойш 30 хоногийн дотор нам, эвсэл, нэр дэвшигчийн дансны гүйлгээний мэдээллийг төрийн аудитын дээд байгууллагад хүргүүлнэ.

МОНГОЛ БАНКНЫ ХЯНАН ШАЛГАГЧ

/Зөрчлийн тухай хуулийн 17.1 дүгээр зүйлийн 26 дахь хэсэгт заасан зөрчил/



26. Сонгуулийн зардлын данс байршуулсан банк сонгуулийн санал авах ажиллагаа дууссан өдрөөс хойш 30 хоногийн дотор нам, эвсэл, нэр дэвшигчийн дансны гүйлгээний мэдээллийг төрийн аудитын дээд байгууллагад хүргүүлэх үүргээ биелүүлээгүй бол хүнийг дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

аудитын байгууллагад хүргүүлэх үүргээ биелүүлээгүй бол, Нэр дэвшигч, нам, эвсэл хандив болон сонгуулийн зардлын зарцуулалтын явцын тайланг санал авах өдрөөс гурав хоногийн өмнө нийтэд ил тод мэдээлж, төрийн аудитын байгууллагад хүргүүлэх үүргээ биелүүлээгүй эсэхийг шалгана.

Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим орчинтой холбоотой зөрчлийг Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Харилцаа холбооны хяналтын улсын байцаагч нар хянаж шалгах аар байгаа. Бусад төрлийн бүхий л зөрчлийг цагдаагийн байгууллага шалгах аар хуульчилсан. Харин прокурорын байгууллага зөрчлийн хэрэг бүртгэлт хуулийн хүрээнд явагдаж байгаа эсэхэд хяналт тавих, илэрсэн зөрчлийг арилгуулах талаар эрх бүхий байгууллагад шаардлага хүргүүлэх ба зөрчлийг хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд оролцоно. Энэ талаар Сонгуулийн ерөнхий хороо Улсын дээд шүүхэд бүртгэлтэй намуудад мэдээлэл өгч, уулзалт зохион байгуулж хамтран ажиллаж байна.


Улс төрийн намын хуульд сонгуулийн байгууллагын эрх нэлээн нэмэгдэж орж ирсэн. Шууд торгох эрх мэдэлтэй болсон бил үү?

Улс төрийн намын тухай хуульд зөрчилтэй холбоотой заалтууд орсон. Тухайлбал, Монгол Улсын иргэд нам үүсгэн байгуулахад дарамт, шахалт үзүүлэх, хөндлөнгөөс оролцсон, намын хяналтын байгууллагын хараат бус

байдалд хөндлөнгөөс нөлөөлөхийг оролдсон бол торгуулийн хариуцлагатай. Үүнийг эрүүгийн хэргийн шүүх хянан шийдвэрлэнэ. Улсын бүртгэлийн хяналтын улсын байцаагчийн хувьд намаас бусад хуулийн этгээд нам гэсэн оноосон нэр хэрэглэсэн бол шалгаж шийдвэрлэнэ. Харин энэ хуулиар сонгуулийн төв байгууллагын эрх бүхий албан тушаалтан Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу хянан шийдвэрлэх ажиллагааг явуулах аар болсон. Нам нь Улс төрийн намын тухай хуулийн 10.1.6-д заасан хориглолтыг зөрчиж мөнгөн хөрөнгө авсан бол тухайн мөнгөн дүнг хоёр дахин үржүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно, мөнгөн бус хөрөнгө, эсвэл үйлчилгээ авсан бол хууль бусаар авсан хөрөнгө, орлогыг хурааж торгохоор заасан. Нам хуульд заасны дагуу өөрчлөн байгуулагдсан тохиолдолд түүний өмч, хөрөнгийг намын гишүүн болон бусад иргэн, хуулийн этгээд аливаа хэлбэрээр өмчлөх, үргэлжлүүлэн хэрэглэсэн бол, Улс төрийн намын тухай хуульд заасан орлогыг банкны нэг дансаар хүлээн аваагүй бол торгох шийтгэл оногдуулах аар заасан.

Нам иргэний болон хуулийн этгээдийн хандивыг бэлэн мөнгөөр хүлээн авсан бол тухайн мөнгөн дүнг хоёр дахин үржүүлнэ. Нам жилд нэг иргэн, хуулийн этгээдээс авах хандивын дээд хэмжээг хуульд зааснаас хэтрүүлэн авсан бол мөнгөн дүнг мөн л хоёр дахин үржүүлэх аар байгаа. Эдгээр торгох заалтыг сонгуулийн байгууллага Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу хянан шийдвэрлэх юм.

“Зууны мэдээ” сонин С.УЯНГА





МОНГОЛ УЛСЫН
СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ
ТОГТООЛ

2024 оны 01 сарын 09 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Цаг хугацааны хуваарь батлах тухай

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.11 дэх хэсэг, Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсгийг үндэслэн ТОГТООХ нь:

1. "Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн үйл ажиллагааг зохион байгуулах цаг хугацааны хуваарь"-ийг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан цаг хугацааны хуваарийн дагуу сонгуулийн бэлтгэл ажлыг хангаж ажиллахыг Хорооны дарга /П.Дэлгэрнаран/, нарийн бичгийн дарга /Д.Даваа-Очир/ нарт даалгасугай.

ДАРГА

П.ДЭЛГЭРНАРАН

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Д.ДАВАА-ОЧИР

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

1524010003

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2024 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЦАГ ХУГАЦААНЫ ХУВААРЬ

2024.02.01

-нээс өмнө

Сонгууль товлон зарлах, санал авах өдөр тогтоох

Улсын Их Хурал ээлжит сонгуулийг сонгуулийн жилийн **02 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө** товлон зарлаж, санал авах өдрийг тогтооно.

(Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн /цаашид "Хуулийн" гэх/ 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг)
(Монгол Улсын Их Хурлын 2023 оны 116 дугаар тогтоол)

Сонгуулийн тойрог байгуулах, мандатын тоо, тойргийн төвийг тогтоох

Улсын Их Хурал ээлжит сонгуулийн жилийн **02 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө** сонгуулийн тойргийг байгуулна.

(Хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг)
(Монгол Улсын Их Хурлын 2023 оны 112 дугаар тогтоол)

Сонгуулийн тойргийг байгуулахдаа аймаг, дүүргийн хүн амын тоо, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хуваарь, газар нутгийн хэмжээ, байршил зэргийг харгалзан байгуулж, тойрогт ногдох **мандатын тоо, дугаар, нутаг дэвсгэр, төвийг тогтооно.**

Сонгуулийн нэг тойрогт хоёр ба хэд хэдэн аймаг, дүүрэг багтаж байвал аль олон сонгогчтой аймаг, дүүргийн сонгуулийн хороо нь тухайн тойрог дахь сонгуулийн зохион байгуулалтын ажлыг хариуцна.

(Хуулийн 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсэг)
(Хуулийн 14 дүгээр зүйлийн 14.17 дахь хэсэг)
(Монгол Улсын Их Хурлын 2023 оны 112 дугаар тогтоол)

2024.03.03

-ны дотор

Сонгуулийн хэсгийн талаарх мэдээллийг хүргүүлэх

Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал сонгуулийн хэсгийг байгуулсан өдрөөс хойш **гурав хоногийн дотор** хуулийн 13.1-д заасан мэдээллийг улсын бүртгэлийн байгууллагын орон нутаг дахь газар, хэлтэст хүргүүлнэ.

(Хуулийн 13 дугаар зүйлийн 13.6 дахь хэсэг)

Улсын бүртгэлийн байгууллагын орон нутаг дахь газар, хэлтэс хуулийн 13.6-д заасан мэдээллийг нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд нэгтгэн **гурав хоногийн дотор** улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

(Хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь хэсэг)

2024.03.01

-нээс өмнө

Сонгуулийн хэсэг байгуулах

Сонгогчдын санал авч, тоолох зорилгоор сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал сонгуулийн хэсгийг ээлжит сонгуулийн жилийн **03 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө** байгуулж, хэсгийн нутаг дэвсгэрийг зарлана.

(Хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэг)

“

**Сонгуулийн үйл ажиллагаа-
ны туршид**

СОНГУУЛИЙН БАЙГУУЛЛАГЫН УДИРДЛАГА

Сонгуулийг улсын хэмжээнд Сонгуулийн ерөнхий хороо удирдан зохион байгуулж, аймаг, сум, нийслэл, дүүргийн сонгуулийн болон хэсгийн хороо, гадаад улсад байгаа иргэдийн санал авах ажлыг зохион байгуулах төв болон салбар комиссыг нэгдсэн удирдлагаар хангаж ажиллана.

(Хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэг)

2024.03.03

-нээс өмнө

Нам, эвсэл, нэр дэвшигчээс сонгуульд зарцуулах зардлын дээд хэмжээ тогтоох

Төрийн аудитын дээд байгууллага нам, эвсэл болон тойрогт нэр дэвшигчээс сонгуульд зарцуулах зардлын дээд хэмжээг ээлжит сонгуулийн жилийн **03 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө** хуулийн 50.2-т заасан аргачлалын дагуу тогтоож, нийтэд мэдээлнэ.

(Хуулийн 50 дугаар зүйлийн 50.1 дэх хэсэг)

2024.03.22, 23, 24

2024.04.22, 23, 24

-ний өдөр

Мөрийн хөтөлбөрт дүгнэлт гаргуулахаар хүргүүлэх

Сонгуулийн мөрийн хөтөлбөртөө дүгнэлт гаргуулахаар төрийн аудитын дээд байгууллагад дараах хугацаанд хүргүүлнэ.

- Нам, эвсэл нь ээлжит сонгуулийн жилийн **03 дугаар сарын 25-ны өдрөөс өмнө**;
- Бие даан нэр дэвшигч нь ээлжит сонгуулийн жилийн **04 дүгээр сарын 25-ны өдрөөс өмнө**

(Хуулийн 38 дугаар зүйлийн 38.6 дахь хэсэг)

2024.04.07

-ны дотор

Хандивын тайландаа дүгнэлт гаргуулахаар хүргүүлэх

Нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь ээлжит сонгуулийн жилийн **04 дүгээр сарын эхний долоо хоногт багтаан** хуулийн 38.13-т заасан хандивын тайландаа дүгнэлт гаргуулахаар төрийн аудитын дээд байгууллагад хүргүүлнэ.

(Хуулийн 38 дугаар зүйлийн 38.7 дахь хэсэг)

“

Дүгнэлт гарснаас хойш 5 хоногийн дотор

МӨРИЙН ХӨТӨЛБӨРТ ДҮГНЭЛТ ГАРГУУЛАХААР ДАХИН ХҮРГҮҮЛЭХ

Нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөр нь хуульд заасан шаардлага хангаагүй гэсэн дүгнэлт гарсан тохиолдолд **тав хоногийн дотор** зөрчлийг арилгасны үндсэн дээр дахин дүгнэлт гаргуулахаар хүргүүлнэ.

(Хуулийн 38 дугаар зүйлийн 38.9 дэх хэсэг)

2024.04.21

-нээс өмнө

Төв комисс байгуулах

Сонгуулийн ерөнхий хороо гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг харгалзан гадаад улсад байгаа иргэдийн санал авах ажлыг зохион байгуулах, нэгдсэн удирдлагаар хангах, хяналт тавих үүрэг бүхий төв комиссыг **гадаадад санал авах өдрөөс 60-аас доошгүй хоногийн өмнө** дарга, нарийн бичгийн дарга болон ес, эсхүл арван нэгэн гишүүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулна.

(Хуулийн 19¹ дүгээр зүйлийн 19¹ дэх хэсэг)

МОНГОЛ УЛСЫН СОНГУУЛИЙН
ЕРӨНХИЙ ХОРОО

2024.04.01 -

2024.06.28

-ныг дуустал

Сонгогчдын нэрийн жагсаалтыг цахим хуудаст байршуулах

Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага сонгогчдын нэрийн жагсаалтад байгаа сонгуулийн эрх бүхий иргэний эцэг /эх/-ийн болон өөрийн нэр, нас, хүйс, иргэний бүртгэлийн дугаар, байнга оршин суугаа газрын хаягийн бүртгэлийн мэдээллийг аймаг, сум, баг, нийслэл, дүүрэг, хороогоор болон хэсэг нэг бүрээр нэгтгэн гаргах бөгөөд уг жагсаалтыг ээлжит сонгуулийн жилийн **04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхэлж, сонгууль дуустал** өөрийн цахим хуудсанд байршуулна.

(Хуулийн 20 дугаар зүйлийн 20.4 дэх хэсэг)

2024.04.19

-нөөс өмнө

Аймаг, нийслэлийн сонгуулийн хороог байгуулах

Сонгуулийн ерөнхий хороо санал авах өдрөөс **70-аас доошгүй хоногийн өмнө** аймаг, нийслэлийн сонгуулийн хороог тухайн аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ирүүлсэн саналыг харгалзан дарга, нарийн бичгийн дарга болон тав, эсхүл долоон гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулж, нийтэд мэдээлнэ.

(Хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэг)

Сонгуулийн нэг тойрогт хоёр ба хэд хэдэн аймаг, дүүрэг багтаж байвал аль олон сонгогчтой аймаг, дүүргийн сонгуулийн хороо нь тухайн тойрог дахь сонгуулийн зохион байгуулалтын ажлыг хариуцна.

(Хуулийн 14 дүгээр зүйлийн 14.17 дахь хэсэг)

2024.04.26, 27, 28

-ны өдөр

Нам, эвсэл сонгуульд оролцохоо илэрхийлэх

Нам, эвсэл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг дагаж мөрдөхөө илэрхийлэн, сонгуульд оролцох тухай зөвхөн нэг хүсэлтээ **санал авах өдрөөс 60-аас доошгүй хоногийн өмнө** Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлнэ.

(Хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэг)

“

Хүлээн авснаас хойш
5 хоногийн дотор**НАМ ЭВСЛИЙГ БҮРТГЭХ
ЭСЭХ ТУХАЙ ШИЙДВЭР
ГАРГАХ**

Сонгуулийн ерөнхий хороо сонгуульд оролцох тухай нам, эвслийн баримт бичгийг **хүлээн авснаас хойш тав хоногт багтаан** сонгуульд оролцох нам, эвслийг бүртгэх эсэх тухай шийдвэр гаргана.

(Хуулийн 28 дугаар зүйлийн 28.2 дахь хэсэг)

2024.04.29**-нөөс эхлэн зогсоож,****2024.06.29****-өөс сэргээнэ****Иргэний шилжилт, хөдөлгөөнийг зогсоох**

Иргэний шилжилт хөдөлгөөнийг **санал авах өдрөөс 60 хоногийн өмнө** зогсоож, санал авах өдрийн **дараах өдрөөс сэргээнэ.**

(Хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг)

2024.05.01 -нээс өмнө**Эрх бүхий байгууллагууд сонгуулийн насны иргэдийн мэдээллийг цаасан болон цахим хэлбэрээр хүргүүлэх**

Доор дурдсан байгууллага дараах иргэний эцэг /эх/-ийн болон өөрийн нэр, иргэний бүртгэлийн дугаар, төрсөн он, сар, өдөр, хүйс, бусад шаардлагатай мэдээллийг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад ээлжит сонгуулийн жилийн 05 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө цаасан болон цахим хэлбэрээр хүргүүлнэ:

- эрх зүйн чадамжгүй нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон сонгуулийн насны иргэдийн мэдээллийг Улсын дээд шүүх;
- хорих ял эдэлж байгаа болон эрүүгийн хэрэгт холбогдуулан баривчлагдсан сонгуулийн насны иргэдийн мэдээллийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага;
- 60 түүнээс дээш хоногийн хугацаагаар гадаад улсад зорчсон иргэдийн мэдээллийг Улсын хил хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага;
- тухайн сум, дүүргийн нутаг дэвсгэрт байнга оршин суух газрын хаягийн бүртгэлгүй боловч санал авах өдөр харьяа тусгай анги, салбарт нь алба хааж байгаа алба хаагч болон ажилтны мэдээллийг Улсын хил хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага;
- тухайн сум, дүүргийн нутаг дэвсгэрт байнга оршин суух газрын хаягийн бүртгэлгүй боловч санал авах өдөр зэвсэгт хүчний цэргийн анги, нэгтгэлд алба хааж байгаа алба хаагч болон ажилтны мэдээллийг батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага;
- тухайн сум, дүүргийн нутаг дэвсгэрт байнга оршин суух газрын хаягийн бүртгэлгүй боловч тухайн нутаг дэвсгэрт ажиллаж байгаа цагдаагийн алба хаагч, дотоодын цэргийн анги, нэгтгэлд алба хааж байгаа алба хаагч болон ажилтны мэдээллийг цагдаагийн төв байгууллага;
- тухайн жилд Монгол Улсын харьяат болсон, иргэний харьяаллаа сэргээн тогтоолгосон, харьяатаас гарсан иргэдийн мэдээллийг гадаадын иргэн, харьяатын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага.

(Хуулийн 20 дугаар зүйлийн 20.6 дахь хэсэг)

2024.04.29**-нөөс өмнө****Сум, дүүргийн сонгуулийн хороог байгуулах**

Аймаг, нийслэлийн сонгуулийн хороо нь сум, дүүргийн сонгуулийн хороог **санал авах өдрөөс 60-аас доошгүй хоногийн өмнө** тухайн сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ирүүлсэн саналыг харгалзан дарга, нарийн бичгийн дарга болон гурав, эсхүл таван гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулж, харьяалах нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд нийтэд мэдээлнэ.

(Хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг)

Нам, эвслийн мөрийн хөтөлбөр болон хандивын тайланд хийсэн дүгнэлтийг хүргүүлэх

Төрийн аудитын дээд байгууллага нам, эвслийн мөрийн хөтөлбөр болон хандивын тайланд хийсэн дүгнэлтийг **санал авах өдрөөс 60-аас доошгүй хоногийн өмнө** гаргаж, Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлнэ.

(Хуулийн 38 дугаар зүйлийн 38.10 дахь хэсэг)

Зурагт самбар байрлуулах байршлыг тогтоож, нийтэд мэдээлэх

Зурагт самбарыг нийтийн эзэмшлийн гудамж, талбай, олон нийтийн газарт үнэ төлбөргүйгээр байрлуулах байршлыг тухайн сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал **санал авах өдрөөс 60-аас доошгүй хоногийн өмнө** тогтоож, нийтэд мэдээлнэ.

(Хуулийн 41 дүгээр зүйлийн 41.3 дахь хэсэг)

2024.05.01 – 2024.06.24**-ний өдрөөс****-нийг дуустал****Сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтан бүртгүүлэх**

Нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтны үнэмлэх авах хүсэлтийг тухайн нам эвслийг бүртгэсэн тухай **шийдвэр гарснаас хойш сонгуулийн сурталчилгаа дуусахаас 2 хоногийн өмнөх өдрийг хүртэлх хугацаанд** дараах байдлаар хүргүүлнэ:

- Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулах сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтны үнэмлэх авах тухай хүсэлтийг Сонгуулийн ерөнхий хороонд;
- Аймаг, нийслэлийн хэмжээнд үйл ажиллагаа явуулах сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтны үнэмлэх авах тухай хүсэлтийг аймаг, нийслэлийн сонгуулийн хороонд;
- Сум, дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулах сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтны үнэмлэх авах тухай хүсэлтийг сум, дүүргийн сонгуулийн хороонд.

(Хуулийн 37 дугаар зүйлийн 37.4, 37.6 дахь хэсэг)

(Сонгуулийн ерөнхий хорооны 2020 оны 17 дугаар тогтоолоор баталсан журам)



2024.05.06

-наас өмнө

Салбар комисс байгуулах

Төв комисс нь салбар комиссыг гадаадад санал авах өдрөөс 45-аас доошгүй хоногийн өмнө дарга болон хоёр, эсхүл дөрвөн гишүүний бүрэлдэхүүнтэйгээр Д и п л о м а т төлөөлөгчийн газрын дэргэд байгуулна.

(Хуулийн 19¹ дүгээр зүйлийн 19² дахь хэсэг)

2024.05.14

-нөөс өмнө

Хэсгийн хороог байгуулах

Сум, дүүргийн сонгуулийн хороо хэсгийн хороог санал авах өдрөөс 45-аас доошгүй хоногийн өмнө дарга болон зургаа, эсхүл найман гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулж, харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд нийтэд мэдээлнэ.

(Хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэг)

2024.05.23

-ны дотор

Нэр дэвшигчид хөрөнгө орлогын мэдүүлгээ мэдүүлэх

Нэр дэвшигч хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа дууссанаас хойш гурав хоногт багтаан нэр дэвшигчийн хөрөнгө, орлогын мэдүүлгээ Авлигатай тэмцэх газарт мэдүүлнэ. Авлигын эсрэг хуульд заасны дагуу хөрөнгө орлогын мэдүүлгээ гаргасан этгээд хамаарахгүй.

(Хуулийн 32 дугаар зүйлийн 32.4 дэх хэсэг)

2024.05.26

-наас өмнө

Бие даан нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийг хүргүүлэх

Төрийн аудитын дээд байгууллага нь бие даан нэр дэвшигчдийн мөрийн хөтөлбөр энэ хуульд заасан шаардлагад нийцэж байгаа эсэх талаарх дүгнэлтийг санал авах өдрөөс 33-аас доошгүй хоногийн өмнө гаргаж, Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлнэ.

(Хуулийн 38 дугаар зүйлийн 38.11 дэх хэсэг)

2024.05.29

-нөөс өмнө

Радио, телевиз сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх тухай мэдэгдлийг хүргүүлэх

Олон нийтийн радио, телевизээс бусад радио, телевиз сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлэг нэвтрүүлэх бол сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх тухай мэдэгдлийг хуульд заасан холбогдох баримт бичиг, мэдээллийн хамт Харилцаа холбооны зохицуулах хороонд санал авах өдрөөс 30-аас доошгүй хоногийн өмнө хүргүүлж, бүртгүүлнэ.

(Хуулийн 46 дугаар зүйлийн 46.9 дэх хэсэг)

2024.05.14 – 2024.05.20

-нөөс

-ныг дуустал

Нэр дэвшүүлэх ажиллагаа

Сонгуульд оролцохоор бүртгүүлсэн нам, эвсэл нэр дэвшүүлэх ажиллагааг санал авах өдрөөс 45 хоногийн өмнө эхлүүлж, долоо хоногийн хугацаанд дуусгана.

(Хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэг)

Бие даан нэрээ дэвшүүлэх ажиллагааг санал авах өдрөөс 45 хоногийн өмнө эхлүүлж, долоо хоногийн хугацаанд дуусгана.

(Хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг)



2024.05.24

-ний дотор

Хөрөнгө орлогын мэдүүлгийн талаарх лавлагааг хүргүүлэх

Авлигатай тэмцэх газар нь нийт нэр дэвшигчид хөрөнгө орлогын мэдүүлгээ мэдүүлсэн эсэх талаарх лавлагааг хуулийн 32.4-т заасан хугацаа дууссанаас хойш нэг хоногийн дотор Сонгуулийн ерөнхий хороонд хүргүүлнэ.

(Хуулийн 32 дугаар зүйлийн 32.5 дахь хэсэг)

2024.05.25

-ны дотор

Нэр дэвшигчдийн баримт бичгийг ирүүлэх

Нэр дэвшүүлсэн нам, эвсэл нь нэр дэвшүүлэх ажиллагааны талаарх хуульд заасан хугацаа дууссан өдрөөс хойш тав хоногт багтаан ... баримт бичгийг Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлнэ.

(Хуулийн 32 дугаар зүйлийн 32.2 дахь хэсгээс)

Бие даан нэрээ дэвшүүлэгч нь бие даан нэрээ дэвшүүлэх ажиллагааны талаарх хуульд заасан хугацаа дууссан өдрөөс хойш тав хоногт багтаан ... баримт бичгийг Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлнэ.

(Хуулийн 32 дугаар зүйлийн 32.3 дахь хэсгээс)



2024.06.01
-ний дотор

Нэр дэвшигчийг
бүртгэх эсэхийг
шийдвэрлэх

Сонгуулийн ерөнхий хороо нэр дэвшигчийн баримт бичгийг хүлээн авах хугацаа дууссанаас хойш долоо хоногийн дотор бүртгэх эсэх асуудлыг шийдвэрлэж, тогтоол гаргана.

(Хуулийн 32 дугаар зүйлийн 32.11 дэх хэсэг)

2024.06.02 – 2024.07.28
-ноос -ныг дуустал

Сонгуулийн зардлын данснаас зарлага гаргах

Нэр дэвшигчийг сонгуульд оролцуулахаар бүртгэсэн өдрөөс эхэлж, сонгуулийн зардлын тайлан гаргах өдрийг дуустал хугацаанд хуулийн 39.2-т заасан арга хэлбэрээр сонгуулийн сурталчилгаа явуулах зориулалтаар сонгуулийн зардлын данснаас дансанд шилжүүлэх хэлбэрээр зарлага гаргаж болно.

(Хуулийн 52 дугаар зүйлийн 52.1 дэх хэсэг)

2024.06.02 – 2024.08.12
-ноос -ныг дуустал

Сонгуулийн зардлын данснаас зарлага гаргах

Нам, эвслийг сонгуульд оролцуулахаар бүртгэсэн өдрөөс эхэлж, сонгуулийн зардлын тайлан гаргах өдрийг дуустал хугацаанд хуулийн 39.2-т заасан арга хэлбэрээр сонгуулийн сурталчилгаа явуулах зориулалтаар сонгуулийн зардлын данснаас дансанд шилжүүлэх хэлбэрээр зарлага гаргаж болно.

(Хуулийн 52 дугаар зүйлийн 52.1 дэх хэсэг)

2024.06.03
-наас өмнө

Сонгогчдын нэрийн жагсаалтыг хэсгийн хороонд хүргүүлэх

Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хуулийн 20.4-т заасны дагуу цахим хуудсанд байршуулсан сонгогчдын нэрийн жагсаалтад дараах өөрчлөлтийг тусган уг жагсаалтыг цаасан болон цахим хэлбэрээр үйлдэж, цаасан хэлбэрээр үйлдсэн сонгогчдын нэрийн жагсаалтыг санал авах өдрөөс 25-аас доошгүй хоногийн өмнө улсын бүртгэлийн байгууллагын орон нутаг дахь газар, хэлтсээр дамжуулан хэсгийн хороонд хүргүүлнэ:

- сонгогчоос хуулийн 20.4-т заасан сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдээгүй, эсхүл буруу бүртгэгдсэн талаар гаргасан гомдлын дагуу оруулсан өөрчлөлт;
- хуулийн 25 дугаар зүйлд заасан хугацаанаас өмнө хийгдсэн сонгогчийн байнга оршин суугаа газрын хаягийн өөрчлөлт;
- сонгогчийн эцэг /эх/-ийн болон өөрийн нэр, хүйс, зэрэг иргэний бүртгэлтэй холбоотой өөрчлөлт;
- нас барсан иргэний улсын бүртгэлтэй холбоотой өөрчлөлт;
- хуулийн 20.6-д заасан иргэдийн мэдээлэлтэй холбоотой өөрчлөлт.

(Хуулийн 20 дугаар зүйлийн 20.9 дэх хэсэг)

2024.06.02
-ны өдрөөс

2024.06.24
-нийг дуустал

Нэр дэвшигчийн менежер, шадар туслагч, ухуулагчаар бүртгүүлэх

Нэр дэвшигчийн менежер, шадар туслагч, ухуулагчийн үнэмлэх авах хүсэлтийг тухайн нэр дэвшигчийг бүртгэх тухай шийдвэр гарснаас хойш сонгуулийн сурталчилгаа дуусахаас 2 хоногийн өмнөх өдрийг хүртэл хугацаанд дараах байдлаар хүргүүлнэ:

- Нэр дэвшигчийн менежерийн үнэмлэх авах хүсэлтийг тойргийн төв-аймгийн сонгуулийн хороонд;
- Шадар туслагчийн үнэмлэхийг аймаг, нийслэлийн сонгуулийн хороо,
- Ухуулагчийн үнэмлэхийг сум, дүүргийн сонгуулийн хороонд.

(Хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, 37.6 дахь хэсэг)
(Сонгуулийн ерөнхий хорооны 2020 оны 17 дугаар тогтоолоор баталсан журам)

2024.06.03
-наас өмнө

Дахин бүртгүүлэх, нөхөн нэр дэвшүүлэх

Нэр дэвшигчээр бүртгэхээс татгалзсан тохиолдолд санал авах өдрөөс 25-аас доошгүй хоногийн өмнө зөрчлийг арилгасны үндсэн дээр дахин бүртгүүлэхээр шаардагдах баримт бичгийг Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлж болно.

(Хуулийн 33 дугаар зүйлийн 33.2 дахь хэсэг)

Дараах тохиолдолд санал авах өдрөөс 25-аас доошгүй хоногийн өмнө өөр хүнийг нөхөн нэр дэвшүүлж болно:

- нэр дэвшигч нас барсан;
- нэр дэвшигч шүүхээр ял шийтгүүлсэн.

(Хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсэг)

Сурталчилгааны төлбөргүй нэвтрүүлгийн хуваарь, цаг батлах

Харилцаа холбооны зохицуулах хороо олон нийтийн радио, телевизээс ирүүлсэн сурталчилгааны болон мэтгэлцээний төлбөргүй нэвтрүүлгийн хуваарь, цагийн талаарх саналыг хянан үзэж, сурталчилгааны болон мэтгэлцээний нэвтрүүлгийн хуваарь, цагийг тэнцүү байхаар тооцож сурталчилгаа эхлэхээс долоогоос доошгүй хоногийн өмнө батална.

(Хуулийн 46 дугаар зүйлийн 46.4 дэх хэсэг)



2024.06.01
-ний өдрөөс эхлэн

Санал авах өдөр, цаг, байрыг нийтэд мэдээлэх

Салбар комисс нь санал авах өдөр, цаг, байрыг санал авах өдөр хүртэлх хугацаанд гадаад улсад байгаа сонгогчдод зарлан мэдээлнэ.

(Хуулийн 64¹ дүгээр зүйлийн 64¹.2 дахь хэсэг)

**2024.06.08,
2024.06.25**
-ны өдөр

**Сонгогчдын нэрийн
жагсаалтыг цахим
хэлбэрээр олгох**

Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага ээлжит сонгуульд оролцохоор бүртгүүлсэн нам, эвслийг төлөөлөх эрх бүхий этгээдийн хүсэлтийн дагуу хуулийн 20.9-т заасан сонгогчдын нэрийн жагсаалтын сонгогчдын эцэг /эх/-ийн болон өөрийн нэр, иргэний бүртгэлийн дугаар, байнга оршин суугаа газрын хаяг бүхий хэсгийг **санал авах өдрөөс 20-иос доошгүй хоногийн өмнө** болон санал авах өдрөөс **3 хоногийн өмнө** тус тус цахим хэлбэрээр олгоно.

(Хуулийн 20 дугаар зүйлийн 20.15 дахь хэсэг)

2024.06.10

-наас өмнө

Нэр дэвшигчийг дахин, нөхөн бүртгэх эсэхийг шийдвэрлэх

Сонгуулийн ерөнхий хороо дахин бүртгүүлэхээр ирүүлсэн баримт бичгийг хүлээн авч, **хуулийн 32.12-т заасан хугацаанаас өмнө** бүртгэх эсэх асуудлыг шийдвэрлэнэ.

(Хуулийн 33 дугаар зүйлийн 33.3 дахь хэсэг)

Сонгуулийн ерөнхий хороо нөхөн нэр дэвшүүлэхээр ирүүлсэн баримт бичгийг хүлээн авч, **хуулийн 32.12-т заасан хугацаанаас өмнө** бүртгэх эсэх асуудлыг шийдвэрлэнэ.

(Хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2 дахь хэсэг)

2024.06.10

-ны өдөр

Нэр дэвшигчийн үнэмлэх олгох, нийтэд мэдээлэх

Нэр дэвшигчийг бүртгэх тухай шийдвэр гарсан бол Сонгуулийн ерөнхий хороо нэр дэвшигчийн үнэмлэхийг **санал авах өдрөөс 18 хоногийн өмнө нэг өдөр** олгож, нийтэд мэдээлнэ.

(Хуулийн 32 дугаар зүйлийн 32.12 дахь хэсэг)

2024.06.10

-наас эхлэн

Нэр дэвшигчдийн хөрөнгө орлогын мэдүүлгийг нээлттэй байршуулах

Нэр дэвшигчид **үнэмлэх олгосон өдрөөс эхлэн** Авлигатай тэмцэх газар нэр дэвшигчээр бүртгэгдсэн нийт нэр дэвшигчийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг өөрийн байгууллагын цахим мэдээллийн сүлжээнд нээлттэйгээр байршуулна.

(Хуулийн 32 дугаар зүйлийн 32.15 дахь хэсэг)



2024.06.10 – 2024.06.26

-наас эхлэн

-ныг дуустал

Сонгуулийн сурталчилгааг эхлүүлэх, зогсоох

Сонгуулийн сурталчилгааг нэр дэвшигчид **үнэмлэх олгосон өдрөөс эхлүүлж, санал авах өдрөөс 24 цагийн өмнө** буюу санал авах өдрийн өмнөх өдрийн **00:00 цагаас өмнө** зогсооно.

(Хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсэг)

Мөнгөн болон мөнгөн бус хандив

Мөнгөн бус хандивыг сонгуулийн **сурталчилгаа эхэлсэн өдрөөс дуусах хүртэл** хугацаанд зөвхөн нэр дэвшигчид өгнө.

(Хуулийн 55 дугаар зүйлийн 55.2 дахь хэсэг)

Мөнгөн бус хандивын үнэлгээг зах зээлийн дундаж ханшийг үндэслэн хандивын гэрээгээр тогтоох бөгөөд уг үнэлгээ нь иргэн болон хуулийн этгээдээс өгөх хандивын дээд хэмжээнээс хэтрэхгүй байна.

(Хуулийн 55 дугаар зүйлийн 55.4 дэх хэсэг)

2024.06.10 – 2024.08.12

-наас эхлэн

-ныг дуустал

Сонгуулийн мөрийн хөтөлбөр, хандивын тайлангийн талаарх дүгнэлтийг цахим хуудаст нээлттэй байршуулах

Төрийн аудитын дээд байгууллага нь хуулийн 38.13-т заасан тайлан, сонгуулийн мөрийн хөтөлбөр болон түүнд хийсэн дүгнэлтийг **санал авах өдрөөс 18 хоногийн өмнөөс эхлэн** хуульд заасны дагуу нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч сонгуулийн зардлын **тайлангаа хүргүүлэх өдрийг дуустал** өөрийн байгууллагын цахим хуудаст нээлттэйгээр байршуулна.

(Хуулийн 38 дугаар зүйлийн 38.12 дахь хэсэг)



“

Зардлын данс нээсэн өдрөөс эхлэн

**МӨНГӨН БОЛОН
МӨНГӨН БУС
ХАНДИВ**

Иргэн, хуулийн этгээдээс нам, эвсэлд, эсхүл сонгуулийн тойрогт нэр дэвшигчид **зардлын данс нээсэн өдрөөс хойш** сонгуулийн үйл ажиллагаанд нь зориулан хуулийн 54.1-т заасан хэмжээнээс хэтрүүлэхгүйгээр сонгуулийн зардлын дансанд хандив өгч болно.

(Хуулийн 54 дүгээр зүйлийн 54.2 дахь хэсэг)

2024.06.13**-наас өмнө****Ажиглагч бүртгүүлэх, үнэмлэх олгох**

Ажиглагч томилох эрх бүхий этгээд гадаад улсад байгаа сонгогчдоос санал авах ажиллагаанд ажиглагч томилох бол энэ тухай хүсэлтээ төв комисст **гадаадад санал авах өдрөөс долоогоос доошгүй хоногийн өмнө** хүргүүлнэ.

(Хуулийн 67 дугаар зүйлийн 67.17 дахь хэсэг)

Сонгуулийн зардлын дансны дугаар, банкны нэрийг бүртгүүлэх

Нам, эвсэл болон нэр дэвшигч сонгуулийн зардлын дансны дугаар, банкны нэрийг **санал авах өдрөөс 15-аас доошгүй хоногийн өмнө** төрийн аудитын дээд байгууллагад мэдэгдэж, бүртгүүлэх үүрэгтэй.

(Хуулийн 51 дүгээр зүйлийн 51.4 дэх хэсэг)

2024.06.15**-наас өмнө****Гадаад улсад байгаа иргэд сонгуульд оролцохоо илэрхийлж, бүртгүүлэх**

Гадаад улсад байгаа иргэн **гадаадад санал авах өдрөөс таваас доошгүй хоногийн өмнө** сонгуульд оролцохоо мэдэгдэж, бүртгүүлнэ.

(Хуулийн 20 дугаар зүйлийн 20.22 дахь хэсэг)

Сонгогч өөрийн байгаа улсын Дипломат төлөөлөгчийн газарт утас, цахим шуудан, факсаар эсхүл биечлэн очиж сонгуульд оролцохоо мэдэгдэж, бүртгүүлнэ.

2024.06.15**-наас эхлэн санал авах өдрийг дуустал****Санал авах өдөр, цаг, байрыг нийтэд мэдээлэх**

Хэсгийн хороо нь санал авах байрын дугаар, нэр, хаяг, байршил, орчин тойрны зураглалыг **14 хоногийн турш** нийтэд зарлан мэдээлнэ.

(Хуулийн 62 дугаар зүйлийн 62.7 дахь хэсэг)

**2024.06.17****-ноос өмнө****Санал авах байрыг бэлтгэх**

Сонгогчоос саналаа нууцаар өгөхөд шаардагдах санал бэлтгэх бүхээг бүхий байр, саналын хайрцгийг **гадаадад санал авах өдрөөс гурваас доошгүй хоногийн өмнө** хуульд заасны дагуу тухайн улсад байгаа Монгол Улсын дипломат төлөөлөгчийн газрын тэргүүн хариуцаж, бэлтгэнэ.

(Хуулийн 641 дүгээр зүйлийн 641.3 дахь хэсэг)

2024.06.14**-нөөс өмнө****Сонгогч нэрийн жагсаалтад бүртгэлтэй эсэхээ шалгах, сонгогчдын нэрийн жагсаалттай холбоотой гомдол гаргах**

Сонгогч сонгогчдын нэрийн жагсаалт дахь өөрийн болон гэр бүлийн гишүүний мэдээлэлтэй танилцах эрхтэй бөгөөд сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдээгүй, эсхүл буруу бүртгэгдсэн бол өөрийн болон гэр бүлийн гишүүний нэрийн өмнөөс гомдлоо итгэмжлэгдсэн ажилтан, эсхүл улсын бүртгэлийн байгууллагад **санал авах өдрөөс 14-өөс доошгүй хоногийн өмнө** бичгээр болон цахимаар гаргана.

(Хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэг)

Сонгогч сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн эсэхээ **санал авах өдрөөс 14-өөс доошгүй хоногийн өмнө** шалгасан байвал зохино.

(Хуулийн 20 дугаар зүйлийн 20.11 дэх хэсэг)

Сонгогчийн шилжилт хийх, бүртгүүлэх

Дараах сонгогчийн шилжилтийг хийх, бүртгэхдээ тухайн байгууллагынх нь албан бичгийг үндэслэн санал авах өдрөөс 14-өөс доошгүй хоногийн өмнө шийдвэрлэнэ.

- Сонгуулийн байгууллагын ажилтан;
- Иргэний бүртгэлийн итгэмжлэгдсэн ажилтан; Мэдээллийн технологийн багийн гишүүн;
- Мэдээллийн технологийн даамал;
- Санал авах байр болон сонгуулийн үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангахаар ажиллаж байгаа цагдаагийн албан хаагч.

(Хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэг)

Дараах сонгогч сонгуулийн нэг хэсгээс нөгөө хэсэгт шилжих бол санал авах өдрөөс 14-өөс доошгүй хоногийн өмнө сонгогчийн шилжилтийг хийлгэж болно.

- Нэр дэвшигч;
- Нэр дэвшигчийн менежер;
- Шадар туслагч.

(Хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг)

2024.06.13**-ны дотор****Сонгуулийн сурталчилгаа явуулах цахим хуудсыг бүртгүүлэх**

Нэр дэвшигч хуулийн 47.1.1, 47.1.2-т заасан цахим хуудсыг сонгуулийн сурталчилгаанд ашиглах тохиолдолд цахим хуудсыг нэр дэвшигчийн **үнэмлэх авсан өдрөөс хойш гурван хоногийн дотор** тухайн аймаг, нийслэлийн сонгуулийн хороонд бүртгүүлнэ.

(Хуулийн 47 дугаар зүйлийн 47.2 дахь хэсэг)

2024.06.20

-НООС ӨМНӨ

Ажиглагч бүртгүүлэх, үнэмлэх олгох

Төв комисс нь гадаад улсад байгаа иргэдээс санал авах ажиллагааг ажиглахаар томилогдсон ажиглагчийн мэдээллийг холбогдох салбар комисст хүргүүлэх бөгөөд ажиглагч нь **гадаадад санал авах өдрөөс өмнө** салбар комисст бүртгүүлж, ажиглагчийн үнэмлэх авна.

(Хуулийн 67 дугаар зүйлийн 67.18 дахь хэсэг)

2024.6.20, 21, 22, 23

-НЫ ӨДРҮҮДЭД ТУХАЙН УЛСЫН ОРОН НУТГИЙН ЦАГААР

07:00-22:00 цаг

Гадаад улсад байгаа иргэдээс санал авах өдөр, цаг

Гадаад улсад байгаа иргэдээс санал авах өдрийг Сонгуулийн ерөнхий хорооны саналыг үндэслэн Улсын Их Хурал тогтоох бөгөөд гадаадад санал авах өдөр нь **дөрөв хүртэл өдөр** байна.


(Хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэг)

(Монгол Улсын Их Хурлын 2023 оны 116 дугаар тогтоол)

Гадаад улсад байгаа сонгогчийн саналыг хуульд заасны дагуу тогтоосон санал авах өдөр, **тухайн улсын орон нутгийн цагаар 07:00-22:00 цаг** хүртэлх хугацаанд салбар комиссын тогтоосон санал авах байранд авна.

(Хуулийн 641 дүгээр зүйлийн 641.1 дэх хэсэг)

(Монгол Улсын Их Хурлын 2023 оны 116 дугаар тогтоол)



2024.06.23

-НААС ӨМНӨ

Ажиглагч бүртгүүлэх,

үнэмлэх олгох

Хэсгийн хороо хүсэлтийг хүлээн авч нягтлан шалгаж, **санал авах өдрөөс таваас доошгүй хоногийн өмнө** ажиглагчийн үнэмлэх олгоно.

(Хуулийн 67 дугаар зүйлийн 67.9 дэх хэсэг)

Зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал өгөх хүсэлтээ байгууллагын удирдлагад болон хэсгийн хороонд хүргүүлэх

Сум, дүүргийн сонгуулийн хороо хуулийн 63.4-т заасны дагуу ирүүлсэн хүсэлт, тодорхойлолтыг **санал авах өдрөөс таваас доошгүй хоногийн өмнө** тухайн сонгогчийн харьяалагдах хэсгийн хороонд хүргүүлнэ.

(Хуулийн 63 дугаар зүйлийн 63.5 дахь хэсэг)

2024.06.21

-НЭЭС ӨМНӨ

Ажиглагч бүртгүүлэх, үнэмлэх олгох

Ажиглагч томилох эрх бүхий этгээд ажиглагч ажиллуулах, бүртгүүлэх хүсэлтээ Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан журмын дагуу бичгээр гаргаж, **санал авах өдрөөс долоогоос доошгүй хоногийн өмнө** хэсгийн хороонд хүргүүлнэ.

(Хуулийн 67 дугаар зүйлийн 67.7 дахь хэсэг)

Санал авах байрыг бэлтгэх

Тухайн хэсгийн харьяалагдах сум, дүүргийн Засаг дарга Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан зааврын дагуу санал авахад шаардлагатай ... зүйлийг **санал авах өдрөөс долоогоос доошгүй хоногийн өмнө** бэлэн болгох үүрэгтэй:

(Хуулийн 62 дугаар зүйлийн 62.2 дахь хэсэг)

Зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал өгөх хүсэлтээ байгууллагын удирдлагад болон хэсгийн хороонд хүргүүлэх

Хуулийн 63.1.1, 63.1.2, 63.1.3, 63.1.4-т заасан сонгогч зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал өгөх хүсэлтээ тухайн байгууллагын удирдлагад өгөх бөгөөд байгууллагын удирдлага уг хүсэлтийг тодорхойлолтын хамт **санал авах өдрөөс долоогоос доошгүй хоногийн өмнө** өөрийн байгууллагын нутаг дэвсгэрийн хувьд харьяалагдах сум, дүүргийн сонгуулийн хороонд хүргүүлнэ.

(Хуулийн 63 дугаар зүйлийн 63.4 дэх хэсэг)

2024.06.25

-НЫ ӨДӨР

Хандив болон зардлын зарцуулалтын явцын тайланг нийтэд мэдээлэх, хүргүүлэх

Нэр дэвшигч, нам, эвсэл авсан хандив болон сонгуулийн зардлын зарцуулалтын явцын тайланг **санал авах өдрөөс гурав хоногийн өмнө** нийтэд ил тод мэдээлж, төрийн аудитын дээд байгууллагад хүргүүлнэ.

(Хуулийн 58 дугаар зүйлийн 58.4 дэх хэсэг)

“

Хүлээн авсан өдрөөс эхлэн

СОНГОГЧ НЭРИЙН ЖАГСААЛТЫН МЭДЭЭЛЭЛТЭЙ ТАНИЛЦАХ

Хэсгийн хороо сонгогчдын нэрийн жагсаалтыг **хүлээн авсан өдрөөс эхлэн** өөрийн ажиллах байранд, өөрийн ажиллах байргүй бол сум, хорооны Засаг даргын Тамгын газрын байранд итгэмжлэгдсэн ажилтныг ажиллуулж, сонгогчдод өөрийн болон өөрийн байнга оршин суугаа хаягийн бүртгэлд бүртгэгдсэн нийт сонгогчийн мэдээлэлтэй чөлөөтэй танилцах боломж олгоно.

(Хуулийн 20 дугаар зүйлийн 20.10 дахь хэсэг)



2024.06.25

-наас өмнө



Сонгогчдын нэрийн жагсаалтыг хэсгийн хороонд хүргүүлэх

Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хуулийн 20.9-д заасан хугацаанд хүргүүлсэн сонгогчдын нэрийн жагсаалтад хуулийн 20.9.1, 20.9.3, 20.9.4, 20.9.5 дахь заалт, 23, 24 дүгээр зүйлд заасан үндэслэлээр оруулсан өөрчлөлт, гадаад улсад саналаа өгсөн сонгогчдын өөрчлөлтийг тусгаж сонгогчдын нэрийн жагсаалтыг **санал авах өдрөөс гурваас доошгүй хоногийн өмнө** улсын бүртгэлийн байгууллагын орон нутаг дахь газар, хэлтсээр дамжуулан хэсгийн хороонд хүргүүлнэ.

(Хуулийн 20 дугаар зүйлийн 20.12 дахь хэсэг)

Сонгогчийн мэдээлэлтэй холбоотой өөрчлөлтийг тусгах

Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санг үндэслэн хуулийн 23.1-д заасны дагуу гомдол гаргасан иргэний мэдээллийн талаар болон иргэний улсын бүртгэлтэй холбоотой өөрчлөлтийн талаар лавлагаа гаргах ба сонгогчийн мэдээлэлтэй холбогдсон өөрчлөлтийг **санал авах өдрөөс гурваас доошгүй хоногийн өмнө** сонгогчдын нэрийн жагсаалтад оруулна.

(Хуулийн 23 дугаар зүйлийн 23.2 дахь хэсэг)

Саналын хуудсыг санал авах байранд хүргүүлэх

Сонгуулийн ерөнхий хороо саналын хуудсыг **санал авах өдрөөс гурваас доошгүй хоногийн өмнө** санал авах байранд хүргүүлэх ажлыг удирдан зохион байгуулна.

(Хуулийн 61 дүгээр зүйлийн 61.2 дахь хэсэг)

Зөөврийн битүүмжилсэн хайрцгаар санал өгөх хүсэлт хүргүүлэх

Эрүүл мэндийн байдлын улмаас зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал өгөх сонгогч өөрийн эрүүл мэндийн талаарх эмчийн магадлагааг зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал өгөх хүсэлтийн хамт **санал авах өдрөөс гурваас доошгүй хоногийн өмнө** хүргүүлнэ.

(Хуулийн 63 дугаар зүйлийн 63.2 дахь хэсэг)



2024.06.27

-ны өдрийн

09:00-20:00 цаг

Зөөврийн битүүмжилсэн хайрцгаар санал авах

... сонгогчийн саналыг зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар түүний хүсэлт, эмнэлгийн магадлагаа, эсхүл холбогдох байгууллагын тодорхойлолтыг үндэслэн **санал авах өдрийн өмнөх өдрийн 09:00-20:00 цагийн** хооронд авна.

(Хуулийн 63 дугаар зүйлийн 63.1 дэх хэсгээс)

2024.06.28

-ны өдрийн

07:00-20:00 цаг

Санал авах өдөр, цаг

Ээлжит сонгуулийн санал авах өдөр нь ээлжит сонгуулийн жилийн **06 дугаар сарын сүүлийн хагасын аль нэг ажлын өдөр** байна.

(Хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэг)
(Монгол Улсын Их Хурлын 2023 оны 116 дугаар тогтоол)

Сонгогчийн саналыг Улаанбаатарын цагаар санал авах өдрийн **07:00 цагаас 22:00 цаг** хүртэл хугацаанд санал авах байранд авна.

(Хуулийн 62 дугаар зүйлийн 62.1 дэх хэсэг)

2024.07.07

-ны дотор

Сурталчилгаа явуулсан тайланг нийтэд мэдээлэх, эрх бүхий байгууллагад хүргүүлэх

Сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх эрх бүхий радио, телевизийн үйлчилгээ эрхлэгч байгууллага сонгуулийн **сурталчилгаа дууссанаас хойш 10 хоногийн дотор** сурталчилгаа явуулсан талаарх тайланг нийтэд мэдээлнэ.

(Хуулийн 39 дүгээр зүйлийн 39.5 дахь хэсэг)

2024.07.13

-ны дотор

УИХ-ын гишүүнээр сонгогдсон тооцсон тухай шийдвэрийг өргөн мэдүүлэх

Сонгуулийн ерөнхий хороо нь сонгуулийн дүн, Монгол Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсон тооцсон тухай шийдвэрийг **сонгууль дууссанаас хойш 15 хоногийн дотор** Улсын Их Хурал болон Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлнэ.

(Хуулийн 74 дүгээр зүйлийн 74.5 дахь хэсэг)

2024.07.28

-ны дотор

Гүйлгээний хуулга гаргаж, аудитын байгууллагад хүргүүлэх

Сонгуулийн зардлын данс байршуулсан банкны захирал, эсхүл салбарын эрхлэгч уг дансны бүх гүйлгээний хуулгыг гаргаж, **санал авах өдрөөс хойш 30 хоногийн дотор** төрийн аудитын дээд байгууллагад хүргүүлнэ.

(Хуулийн 57 дугаар зүйлийн 57.5 дахь хэсэг)

Сонгуулийн зардлын тайланг хүргүүлэх

Дэвшигч **санал авах өдрөөс хойш 30 хоногт багтаан** зардлын тайландаа хувийн аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулан, төрийн аудитын дээд байгууллагад хүргүүлнэ.

(Хуулийн 57 дугаар зүйлийн 57.3 дахь хэсэг)

2024.09.26

-ны дотор

Сонгуулийн зардлын тайланг хянах, нийтэд мэдээлэх

Нэр дэвшигч:Төрийн аудитын дээд байгууллага зардлын тайланг **хүлээн авсан өдрөөс хойш 60 хоногийн дотор** хянаж, дүнг нийтэд мэдээлэх бөгөөд нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийг нийтэд мэдээлнэ.

(Хуулийн 58 дугаар зүйлийн 58.1 дэх хэсэг)

2024.10.15

-ны дотор

Сонгууль зохион байгуулах улсын төсвийн зардлын тайлан гаргах

Хуулийн 10.1, 10.2, 10.3, 10.4-т заасан зардлын зарцуулалт, гүйцэтгэлийн тайланг ээлжит сонгуулийн жилийн **10 дугаар сарын 15-ны дотор** гаргаж, төрийн аудитын дээд байгууллагад хүргүүлнэ.

(Хуулийн 10 дугаар зүйлийн 10.9 дэх хэсэг)

2024.07.17

-ны дотор

Сурталчилгаа явуулсан тайланг нийтэд мэдээлэх, эрх бүхий байгууллагад хүргүүлэх

Сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх эрх бүхий радио, телевиз нь хуулийн 39.5-д заасны дагуу нийтэд мэдээлсэн тайланг шударга өрсөлдөөний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад **нийтэд мэдээлснээс хойш ажлын 5 өдрийн дотор** хүргүүлнэ.

(Хуулийн 39 дүгээр зүйлийн 39.7 дахь хэсэг)

2024.08.28

-ны дотор

Сонгуулийн зардлын тайланг хүргүүлэх

Нам, эвсэл **санал авах өдрөөс хойш 45 хоногт багтаан** зардлын тайландаа хувийн аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулан, төрийн аудитын дээд байгууллагад хүргүүлнэ.

(Хуулийн 57 дугаар зүйлийн 57.3 дахь хэсэг)

2024.10.11

-ны дотор

Сонгуулийн зардлын тайланг хянах, нийтэд мэдээлэх

Нам, эвсэл:Төрийн аудитын дээд байгууллага зардлын тайланг **хүлээн авсан өдрөөс хойш 60 хоногийн дотор** хянаж, дүнг нийтэд мэдээлэх бөгөөд нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийг нийтэд мэдээлнэ.

(Хуулийн 58 дугаар зүйлийн 58.1 дэх хэсэг)



УЛС ТӨРИЙН САНХҮҮЖИЛТ, СОНГУУЛИЙН ШИНЭЧЛЭЛИЙН АСУУДЛУУД

Намын дотоод ардчилал,
нэр дэвшүүлэх процесс

Democracy is only possible if people are prepared to put themselves forward for a chance to represent their community.

Д.ЭНХЦЭЦЭГ


Нээлттэй Нийгэм
Форумын Засаглалын
хөтөлбөрийн менежер,
судлаач

Нэг. ТАНИЛЦУУЛГА

Ардчилсан тогтолцоонд улс төрийн намууд нь иргэд сайн дурын үндсэн дээр эвлэлдэн нэгдэж улс төрийн хүсэл зориг, үзэл бодлоо илэрхийлэх, улс төрийн эрх мэдэлд хүрэх, засаглалд оролцох гүүр болдог. Энэ утгаараа засгийн бүх эрх ард түмний мэдэлд байх Үндсэн хуулийн зарчмыг хэрэгжүүлэхэд нэн чухал үүрэгтэй ардчиллын институци билээ. Сонгуульд оролцон нийт ард түмнийг төлөөлөн шийдвэр гаргах эрх мэдэлд хүрэх гүүр болдог учир улс төрийн намын дотоод ардчилалтай, нийгмийн бүх гишүүдийн эрх, ашиг сонирхол, хэрэгцээг өргөн хүрээнд тэгш төлөөлөхийн төлөө чармайлх учиртай. Үүгээр хууль ёсны гэж хүлээн зөвшөөрөгдөх легитим чанар нь баталгаажиж төлөөллийн ардчиллын институцийн хувьд байр суурь нь батжих нөхцөл бүрддэг.

Монгол улс нэг нам дангаар ноёрхсон тогтолцоог халж, шинэ ардчилсан Үндсэн хуульдаа Монгол улсын иргэд "нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй" [...] болохыг тунхаглан баталгаажуулснаас хойш одоогийн байдлаар 37 нам Улсын Дээд Шүүхэд албан ёсоор бүртгүүлжээ. Гэвч судлаачдын дүгнэснээр өнөөг хүртэл Монгол улсад үнэт зүйл, үзэл санааны хувьд нийтэд танигдан хүлээн зөвшөөрөгдөж, нийгэмд эзлэх байр суурь нь тогтворжсон, сонгогчидтой байнгын харилцаатай, байгууллагын зохион байгуулалт, процесс, төлөвшлийн хувьд институтчлэгдсэн нам тун цөөн байна. (Casal Bértoa & Бат-Оргил, 2021) Өнгөрсөн хэд хэдэн парламентын сонгуульд эрх баригч намд парламентын суудлын 50-с дээш хувийг авч ирсэн дүнгээс үзэхэд Монгол улсад нэг нам давамгайлсан намын систем тогтох шинж илэрч байгааг улс төр судлаачид тэмдэглэх болсон. (Гэрэлт-Од, 2021) Ардчилсан тогтолцоотой улсуудад нэг нам давамгайлсан систем нь ердийн үзэгдэл боловч ардчилал нь харьцангуй шинэ, өөр дэглэмтэй улсуудын дунд хавчуулагдсан Монгол Улс шиг орнуудын ардчилалд тийм ч таатай үзэгдэл биш болохыг Фиш тэргүүтэй судлаачид онцолсон байдаг. (Фиш & Сиберг, 2017)

График 1: 1992 оны ардчилсан Үндсэн хуулиас хойших сонгуулиудын дүн



Эх сурвалж: Сонгуулийн ерөнхий хороо www.gec.gov.mn

Намын системийн өнөөгийн төлөв байдал бүрэлдэхэд сонгуулийн тогтолцоо, улс төрийн санхүүжилт гэх мэт янз бүрийн хүчин зүйл нөлөөлж ирсэн нь гарцаагүй боловч улс төрийн намын доторх манлайлал, дотоод ардчилал нь хангалтгүй байдал ч мөн нөлөөлж буй билээ. Үүнээс үүдэн сүүлийн жилүүдэд улс төрийн намтай холбоотой эрх зүйн орчинд хэд хэдэн удаагийн томоохон шинэчлэл хийгдэв.

Юун түрүүнд 2019 онд Үндсэн хуульд туссан нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд “улс төрийн намын дотоод зохион байгуулалт ардчилсан зарчимд нийцсэн, хөрөнгө орлогын эх үүсвэр, зарцуулалт нь нийтэд ил тод байна. Намын зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, санхүүжилт, төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх нөхцөлийг хуулиар тогтооно”

гэж тусгасан. (МУҮХ-ийн 19') Түүнчлэн 2023 онд Үндсэн хуульд дахин нэг өөрчлөлт нэмэгдсэн нь “Улсын Их Хурал нэг танхимтай, нэг зуун хорин зургаан гишүүнтэй байна. Улсын Их Хурлын сонгуулийг сонгуулийн холимог тогтолцоогоор явуулна. Улсын Их Хурлын далан найман гишүүнийг олныг төлөөлөх, дөчин найман гишүүнийг хувь тэнцүүлэн төлөөлөх аргаар сонгоно” гэжээ. (МУҮХ 21.1)

Улмаар Үндсэн хуульд туссан дээрх өөрчлөлтүүдийн хүрээнд 2023 онд УИХ-аас Улс төрийн намын тухай хууль болон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийг шинэчилж, нэмэлт, өөрчлөлт тусган батлаад байна. Шинээр баталсан Улс төрийн намын тухай хуульд намын дотоод ардчиллыг бүрэлдүүлж сахихад шаардлагатай бүтэц,

дүрэмд заавал тусгах асуудлыг зааснаас гадна төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэгийг зөвхөн парламентад суудалтай намуудаар хязгаарлахгүй сонгуулийн амжилтад нь үндэслэн олгох зохицуулалтууд багтжээ. УИХ-ын сонгуулийн хуулийн тухайд холимог тогтолцоогоор сонгуулийг зохион байгуулах асуудлыг нарийвчлан зохицуулсны дотор хувь тэнцүүлэн төлөөлөх аргаар сонгох 48 суудлын төлөө өрсөлдөх намын жагсаалтын нэр дэвшигчдийг 1:1 хүйсийн харьцаатай байх шаардлагыг тусгажээ.

2024 оны УИХ-ын ээлжит сонгуулийг хаяанд ирээд буй энэ үед эрх зүйн орчинд хийгдсэн эдгээр шинэчлэл нь ямар бодитой үр дүн үзүүлэх вэ гэсэн асуулт зүй ёсоор тавигдана. Ялангуяа **УИХ-ын суудлын тоо 40 хувиар нэмэгдсэнтэй холбоотой холимог тогтолцоогоор** явагдах сонгуулиар шинээр бүрдэх парламент нь **чадварлаг, ёс зүйтэй, нийтийн итгэлийг хөсөрдүүлэлгүй ажиллах бүрэлдэхүүн байх чадах уу?** Үүний баталгааг хангаж улс төр дэх мөнгөний зүй бус нөлөөнөөс ангид, олны итгэл хүлээх чансаатай нэр дэвшигчид сонгуульд өрсөлдөх баталгаа бий юу?

Эрх зүйн шинэчлэлийн хүрээнд дээрх асуултуудтай холбоотой зарим зохицуулалт хуулиудад туссан байх боловч хуулийн хэрэгжилтийг хангаж, бодитой үр дүнд хүргэхэд гол үүрэг гүйцэтгэх тал нь гарцаагүй улс төрийн намууд билээ. Ялангуяа дотоод ардчиллыг хангах, үүний дотор намын дотоод сонгууль гэх мэт асуудал нь намын дүрэм, зохион байгуулалттай шууд холбоотой асуудал тул хуулиар нарийвчлан зохицуулах боломжгүй бөгөөд олон улсын стандартыг авч үзвэл чингэх нь угаасаа зохимжгүй юм.¹ Энэ нөхцөлд хуулиар тогтоосон ерөнхий зарчим, зарим тодорхой шаардлагын хүрээнд улс төрийн намууд өөрсдөө юуны түрүүнд манлайлал үзүүлж дотоод ардчилалтай холбоотой асуудлуудаа олон улсын чиг хандлага, сайн туршлагад дөхүүлэн шинэчлэх нь хэтдээ намын төлөвшил, намын системийн хөгжилд сайн нөлөө үзүүлнэ гэж үзэж байна.

¹ Улс төрийн нам нь сонгуулиар дамжуулж төрийн эрх барих мандат олж авдаг онцгой үүрэг бүхий институци мөн боловч, нөгөө талаар иргэдийн сайн дурын үндсэн дээр эвлэлдэн нэгдсэн байгууллага болно. Тиймээс Венецийн комиссоос гаргасан Улс төрийн намын тухай хууль тогтоомжийг боловсруулах удирдамжид улс төрийн намын тухай хуульд намын дотоод асуудалд хэт гүнзгий оролцсон зохицуулалт байх нь зохимжгүй болохыг дурдсан байдаг.

“

УИХ-ын сонгуулийн хуулийн тухайд холимог тогтолцоогоор сонгуулийг зохион байгуулах асуудлыг нарийвчлан зохицуулсны дотор хувь тэнцүүлэн төлөөлөх аргаар сонгох

48 СУУДЛЫН ТӨЛӨӨ ӨРСӨЛДӨХ НАМЫН ЖАГСААЛТЫН НЭР ДЭВШИГЧДИЙГ



1:1 хүйсийн харьцаатай
байх шаардлагыг тусгажээ.

”



Улс төрийн судалгааны Европын консорциумын тодорхойлсноор²,

Улс төрийн намын дотоод ардчиллын асуудалд зайлшгүй хамаарах хэд хэдэн зүйл байна. Үүнд намын бүтэц, зохион байгуулалтыг тодорхойлсон дүрэм. Эдгээр дүрэм нь ил тод, намын гишүүдэд ойлгомжтой байх ёстой бөгөөд зөвхөн тогтсон дүрмийн дагуу өөрчлөх боломжтой байх ёстой. Намын удирдлагыг сонгуулиар сонгодог байх ёстой. Түүнчлэн, сонгуульд өрсөлдөх нэр дэвшигчийг зөвхөн намын дарга ганцаараа биш, тодорхой хүрээнд хамтын шийдвэр байх ёстой.

Энэхүү нийтлэлд намын дотоод ардчилалтай холбоотой нэр дэвшигчийг тодруулах үйл явцыг онцлон Улс төрийн намын тухай хууль болон УИХ-ын сонгуулийн тухай хуульд туссан зохицуулалт, сонгуульд өрсөлдөх нэр дэвшигчдээ тодруулахад намууд дагаж ирсэн процесс, олон улсын туршлага зэргийг танилцуулж, тэдгээрт үндэслэн тодорхой зөвлөмж санал болгоно.

Хоёр. ХУУЛЬ ТОГТООМЖИД ТУССАН ЗОХИЦУУЛАЛТ

Төлөөллийн ардчиллын процессын хувьд нэр дэвшүүлэх үйл ажиллагаа нь сонгуулийн тогтолцоотой ижил ач холбогдолтой бөгөөд намуудын зүгээс ардчилалд оруулах нэг хэлбэрийн хувь нэмэр болохыг улс төр судлаач эрдэмтэд онцолсон байдаг. (Rahat, 2023)

Нэр дэвшигчдээ тодруулах сонгууль нь намын дотоод үйл ажиллагаа тул хуулиар нарийвчлан зохицуулах нь ховор байна. Улс орнуудыг туршлагыг харахад хуульд ихэвчлэн нэр дэвшигчдэд тавих зарим шалгуур, нэр дэвшигчдийг тодруулахад баримтлах ерөнхий зарчмыг заахаас хэтэрдэггүй.

2023 онд УИХ-аас шинэчилсэн баталсан Улс төрийн намын тухай хууль болон нэмэлт, өөрчлөлт оруулсан УИХ-ын сонгуулийг хуулиудыг харьцуулж үзэхэд нэр дэвшүүлэхэд баримтлах ерөнхий зарчим, нэр дэвшигчдэд тавих бусад шаардлага болон төлөөллийг хангах, шийдвэр гаргах болон зохион байгуулалттай холбоотой хэд хэдэн ерөнхий зохицуулалт тусгагджээ. Хуулийн хүрээнд ардчилсан зарчимд нийцүүлэн нэр дэвшигчдийг тодруулах үйл ажиллагааны дүрэм гаргаж, хэрэгжүүлэх нь намуудын санаачилгаас голлон хамаарахаар байна.

Улс төрийн намын тухай хуулийн 15.2.8 дахь хэсэгт нам дүрэмдээ "15.2.8.төрийн улс төрийн албан тушаалд болон намын удирдах албан тушаалд нэр дэвшигчийг сонгох, томилох, чөлөөлөх, тэдгээрт жендэрийн тэгш байдлыг хангах журам"-аа тусгаж батлах шаардлагатайг заажээ. Уг хуулийн дагуу намын дүрмийг батлах нь улс төрийн намын удирдах дээд байгууллагын онцгой бүрэн эрхэд хамаарах асуудал байна. /17.2.1/ Мөн хуулийн 17.4-д "Намын төлөөллийн төв байгууллагын гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь санал гаргавал намын дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж болно. Энэ нэмэлт, өөрчлөлт нь намын дүрмийн гуравны нэгээс хэтрэхгүй байна" гэжээ. Эндээс үзэхэд нам төрийн сонгуульд оролцох нэр дэвшигчдээ тодруулах журам нь дотоод ардчиллын чухал асуудал тул гишүүдийнхээ өргөн оролцоотой хэлэлцэж шийдвэрлэх байдлаар зохицуулжээ гэж ойлгож болохоор байна.

Үүнээс гадна УИХ-ын сонгуулийн хуульд сонгуульд оролцох нам, эвсэлд хүсэлтээ СЕХ-нд хүргүүлэхдээ хуульд заасан буюу шаардлагад нийцсэн нэр дэвшүүлэх ажиллагааны талаарх намын дотоод журам" заавал хавсаргахаар заажээ.³ /26.3.5/ Иймд сонгуульд оролцох бэлтгэлээ базааж буй намууд 2024 оны 1 сарын 1-нээс эхлэн хэрэгжиж буй Улс төрийн намын тухай хууль болон сонгуулийн хуульд сонгуульд нэр дэвшүүлэх үйл ажиллагааг нарийвчлан зохицуулсан дотоод дүрмээ нийцүүлэн батлах нь цаг тулгамдсан асуудал болоод байна.

Дээр дурдсан хуулиудад туссан нэр дэвшигчдийг тодруулах процесстэй холбоотой зохицуулалтыг харьцуулж үзвэл:

2 There are several properties of parties that 'should' be subject to internal democracy. Among these properties are the rules for how the organization of the party is structured. These rules should be transparent and known to the party members and the rules can only be changed following established and recognized procedures. Access to the leadership positions in the party should be through elections. Similarly, nomination of candidates for elections must involve a defined 'selectorate' and not limited to the preferences of a single leader.

3 Хүснэгтэд байгаа шаардлагуудаас гадна нэр дэвшигч нь төрийн жинхэнэ албан хаагч, төрийн үйлчилгээний албаны удирдах адбан тушаалтан, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн дарга, дэд дарга, захирал, дэд захирлын ажил, албан тушаал эрхэлж байгаа бол сонгуулийн жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө эрхэлсэн ажил, албан тушаалаасаа чөлөөлөгдсөн байхыг хуулиар шаарддаг. /МУИХСтХ 29.4/ Түүнчлэн сонгуульд эвсэл болж нэгдэн оролцож байгаа намуудын хувьд хуулийн 27.2.-д зааснаар "Эвсэлд нэгдэж байгаа намын Их хурал, эсхүл төлөөллийн төв байгууллага нь нэр дэвшүүлэх асуудлыг нууц санал хураалтаар шийдвэрлэнэ." гэжээ

Хүснэгт 1: Нэр дэвшигчдийг тодруулахтай холбоотой зохицуулалт

Улс төрийн намын тухай хууль /2024 оны 1 сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн/	Монгол Улсын их хурлын сонгуулийн тухай хууль /2019 он/
НЭР ДЭВШИГЧДИЙГ ТОДРУУЛАХАД БАРИМТЛАХ ЕРӨНХИЙ ЗАРЧИМ, ШААРДЛАГА	
Улс төрийн намын дотоод зохион байгуулалт, үйл ажиллагааг ардчилсан зарчимд нийцүүлэх: • Нам гишүүдээ намын удирдах байгууллага, албан тушаал, сонгуульд нэр дэвших, сонгох, томилоход аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхахгүй байж, тэгш боломж олгоно. /8.1/ • Намын дүрэм, хөтөлбөрийг батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах болон сонгуульд нэр дэвшигчийг санал болгоход намын гишүүдийн оролцоог хангаж, саналыг сонсоно. /8.4/ • Нам бодлого, үйл ажиллагаандаа хувь хүн болон нийгмийн бүлгийг аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхахыг хориглоно. /8.6/	• Нам, эвсэл нэр дэвшүүлэхдээ ардчилсан ёс, шударга ёсны зарчмыг баримталж, нийгмийн бүлгийн төлөөллийг харгалзана. /29.10/ • 25 насанд хүрсэн, сонгуулийн эрх бүхий, энэ хуульд заасан шаардлагыг хангасан Монгол Улсын иргэн Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдох эрхтэй. /5.3./ • Нам, эвсэл нь 78 хүртэл хүнийг энэ хуульд заасны дагуу байгуулагдсан сонгуулийн тойрогт, 48 хүртэл хүнийг нам, эвслийн нэр дэвшигчдийн жагсаалтаар тус тус нэр дэвшүүлнэ. /30.1/
ШИЙДВЭР ГАРГАХ БОЛОН ЗОХИОН БАЙГУУЛАЛТТАЙ ХОЛБООТОЙ ЗОХИЦУУЛАЛТ	
Нам Монгол Улсын Их Хурлын сонгуульд намаас нэр дэвшигчийг сонгох ажлыг зохион байгуулах хороотой байж болно. Хорооны бүрэлдэхүүнд тавих шаардлага, түүнийг байгуулах, ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах болон үйл ажиллагааны журмыг энэ хуулийн 8 дугаар зүйл, намын дүрэмд нийцүүлнэ. /19.4./	30.5. Намаас нэр дэвшүүлэх асуудлыг тухайн намын Их хурал, эсхүл төлөөллийн төв байгууллага хуралдаанаараа хэлэлцэж, нууцаар санал хурааж, олонхын саналаар шийдвэрлэнэ.
ХОРИГЛОСОН ЗОХИЦУУЛАЛТ	
Нам дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно: • хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол зэргээр нь ялгаварлан гадуурхах /10.1.4./ • сонгуульд нэр дэвших эрх олгохдоо намын гишүүн, дэмжигчээсээ барьцаа, дэнчин болон бусад аливаа хэлбэрээр мөнгө болон мөнгөн бус хөрөнгө, үйлчилгээ өгөхийг шаардах, авах /10.1.6./	• Нэг намын гишүүнийг өөр намаас, эвслийн тухайд түүнд нэгдэн орсон намуудаас өөр намын гишүүнийг нэр дэвшүүлэхийг хориглоно. /29.5/ • Нэр дэвшигч нь нэгээс илүү тойрогт нэр дэвшихийг хориглоно. /29.6/ • Гэмт хэрэг үйлдэж шүүхийн хүчин төгөлдөр шийтгэх тогтоолоор ял эдэлж байгаа хүн нэр дэвшихийг хориглоно. /29.8./ • Авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоогдсон бол нэр дэвшихийг хориглоно. /29.9./ • Нам, эвсэл нэр дэвшүүлэхдээ намын гишүүн, дэмжигчээсээ мөнгөн болон мөнгөн бус хөрөнгө, үйлчилгээ, барьцаа, дэнчин авахыг хориглоно. /30.3/



НЭР ДЭВШИГЧДЭД ТАВИХ БУСАД ШААРДЛАГА БОЛОН ТӨЛӨӨЛЛИЙГ ХАНГАХТАЙ ХОЛБООТОЙ ЗОХИЦУУЛАЛТ

Нэр дэвшүүлэхэд аль нэг хүйсийн төлөөлөл 30 хувиас доошгүй байна /8.2.3./

- Нэр дэвшигч хуульд заасан нийтлэг шаардлагаас гадна дараах шаардлагыг хангасан байна / 29.3./
- банк, бусад хуулийн этгээд, иргэнд шүүх болон арбитрын шийдвэрээр тогтоогдсон төлбөл зохих зээл, барьцаа болон батлан даалтын өр төлбөргүй байх /29.3.1/
- татварын хугацаа хэтэрсэн өр төлбөргүй байх, аль нэг компанийн 51, түүнээс дээш хувийн хувьцаа эзэмшдэг бол тухайн компани нь албан татварын хугацаа хэтэрсэн өргүй байх /29.3.2/
- сүүлийн 6 хүртэл жилийн хугацаанд Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан Төсвийн тогтвортой байдлын зөвлөлд гишүүнээр ажиллаж байгаагүй. /29.3.3/
- Нам, эвслээс нэр дэвшүүлэхэд 2024 оны ээлжит сонгуулиар нийт нэр дэвшигчийн 30-аас доошгүй хувь нь, 2028 оны ээлжит сонгуулиар 40-өөс доошгүй хувь нь аль нэг хүйсийнх байна. /30.2/
- Нам, эвсэл жагсаалтаар нэр дэвшүүлэхдээ 1:1 хүйсийн харьцаатай жагсаалтын дарааллыг үндэслэн нэр дэвшүүлнэ. /30.6/

Сонгуульд нэр дэвшигчдийг тодруулах процесс нь нэлээд хугацаа шаардах улс төрийн чухал шийдвэр бөгөөд холбогдох журмын хүрээнд нэр дэвших боломжтой гишүүдийн жагсаалт үүсгэх, сонгон шалгаруулах, эцэслэн шийдэх, тойрогт хуваарилах, намын жагсаалтад эрэмбэлэх зэрэг олон чухал асуудлыг тусгах шаардлагатай. Энэ үйл явц нь Үндсэн хуульд заасан намын дотоод үйл ажиллагаа ардчилсан зарчимд нийцсэн байх шаардлагыг хангах нь туйлын чухал юм.

Шинээр бүрэлдсэн эрх зүйн орчны хүрээнд нам дүрмээ батлах, шинэчлэх нь зохион байгуулалтын хувьд амаргүй ажил боловч намуудын хувьд өмнөх туршлага, алдаа, оноогоо цэгнэн дотоод зохион байгуулалт, үйл ажиллагаа, түүний дотор төрийн сонгуульд өрсөлдөх нэр дэвшигчдээ тодруулах үйл явцыг ардчилсан зарчим, олон улсын сайн туршлага, улс төрийн намуудын хөгжлийн чиг хандлагад нийцүүлэх нэг боломж юм.

Үргэлжлэл бий...


ГАДААД УЛСАД БАЙГАА СОНГОГЧДЫН САНАЛЫГ 2024 ОНЫ 06 ДУГААР САРЫН 20, 21, 22, 23-НЫ ӨДРҮҮДЭД АВНА

Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн хүрээнд Улсын Их Хурлын 48 гишүүнийг намын жагсаалтаар сонгохоор хуульчилсан. Үүнтэй холбоотойгоор Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулиар гадаад улсад байгаа сонгогчдын саналыг 2024 оны 06 дугаар сарын 20, 21, 22, 23-ны өдрүүдэд буюу 4 хоногийн хугацаанд авахаар болсон юм. Гадаад улсад байгаа иргэн гадаадад санал авах өдрөөс таваас доошгүй хоногийн өмнө буюу 2024 оны 06 дугаар сарын 15-наас өмнө сонгуульд оролцохоо мэдэгдэж, бүртгүүлнэ. Харьяалах Дипломат төлөөлөгчийн газарт хандахдаа



сонгогч Та заавал биечлэн очих шаардлагагүй бөгөөд харилцаа холбооны (утас, факс, мэйл, цахим хуудас, чат гэх мэт...) бүхий л хэлбэрийг ашиглан бүртгүүлэх боломжтой. Харин санал авах өдөр сонгогч Та өөрийн биеэр санал авах байранд ирж, иргэний үнэмлэх, эсхүл үндэсний гадаад паспортыг сонгогчдын нэрийн жагсаалттай тулгаж, баталгаажуулсны үндсэн дээр саналаа өгөх юм. Гадаад улсад байгаа сонгогчийн саналыг Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд заасны дагуу тухайн улсын орон нутгийн цагаар 07:00-22:00 цаг хүртэлх хугацаанд салбар комиссын тогтоосон санал авах байранд авна.



СОНГУУЛЬД ОРОЛЦОХОО
МЭДЭГДЭЖ, БҮРТГҮҮЛНЭ.



ӨДРҮҮДЭД БУЮУ 4 ХОНОГИЙН
ХУГАЦААНД АВНА
07:00-22:00



тухайн улсын орон
нутгийн цагаар
07:00-22:00 цаг
хүртэлх хугацаанд
салбар комиссын
тогтоосон санал
авах байранд авна.



Төв комисс байгуулах

Сонгуулийн ерөнхий хороо гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг харгалзан гадаад улсад байгаа иргэдийн санал авах ажлыг зохион байгуулах, нэгдсэн удирдлагаар хангах, хяналт тавих үүрэг бүхий төв комиссыг **гадаадад санал авах өдрөөс 60-аас доошгүй хоногийн өмнө** дарга, нарийн бичгийн дарга болон ес, эсхүл арван нэгэн гишүүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулна.

(Хуулийн 19¹ дүгээр зүйлийн 19¹ дэх хэсэг)



Салбар комисс байгуулах

Төв комисс нь салбар комиссыг гадаадад санал авах өдрөөс 45-аас доошгүй хоногийн өмнө дарга болон хоёр, эсхүл дөрвөн гишүүний бүрэлдэхүүнтэйгээр Дипломат төлөөлөгчийн газрын дэргэд байгуулна.

(Хуулийн 19¹ дүгээр зүйлийн 19² дахь хэсэг)



УЛС ТӨРИЙН НАМЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧЛЭЛ

Э.Гэрэлт-Од, МУБИС-ийн Нийгмийн ухааны тэнхимийн багш,
улс төр судлаач, доктор (PhD)



Монгол Улсын Их Хурал 2023 оны долоодугаар сарын 7-ны өдөр Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталсан. Энэ нь хариуцлагатай улс төр, парламентын засаглалыг төлөвшүүлэхэд чиглэсэн хүчин чармайлт байсан юм. Хуульд улс төрийн намыг нээлттэй, ил тод, хариуцлагатай, дотоод ардчилал, хүний эрхийг дээдэлсэн бодлогын нам болж төлөвшүүлэхээр тусгасан.

Учир нь 1990 онд батлагдсан “Улс төрийн намуудын тухай хууль” болон 2005 онд шинэчилсэн найруулсан “Улс төрийн намын тухай хууль”-иуд цагтаа түүхэн үүрэг гүйцэтгэсэн “шилжилтийн” шинжтэй байсан ч, өнөөдөр үзэл баримтлал нь хуучирч, нийгэм-улс төрийн хэрэгцээ шаардлагыг хангахгүй байсан юм. Мөн өнгөрсөн хугацаанд улс төрийн намууд, улс төрчид хуулийг шинэчлэн найруулах шаардлагатай гэсэн ч улс төрийн хүсэл зориг бүрдэхгүй байсан.

Тиймээс өнгөрсөн 34 жилийн хугацаанд улс төрийн нам эрх зүйн орчин, үр дагаврыг нь тодорхойлж, үүсээд байсан олон нийтийн хүлээлт ямар байсан, шинэ хуулийн үзэл баримтлал, зохицуулалтууд, түүний ач холбогдлыг тоймлолоо.

Нэг. УЛС ТӨРИЙН НАМЫН ТУХАЙ ХУУЧИН ХУУЛИУДЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ, ҮР ДАГАВАР

1990 оны БНМАУ-ын Улс төрийн намуудын тухай хууль нь нийгэм, улс төрийн шилжилтийн хууль байсан бөгөөд БНМАУ-ын АИХ-ын 11 дэх удаагийн сонгуулийн 9-р чуулганаар 363 депутатаас 356 (96,7%) ирцтэй хэлэлцэж 5 сарын 10-нд баталсан түүхтэй. ¹ Улс төрийн намуудын тухай хууль нь 5 бүлэг, 35 зүйлтэй хууль ² байсан бөгөөд 2005 он хүртэл нийт 11 удаа нэмэлт, өөрчлөлт орсон. Шинэ хууль хэрэгжиж эхэлснээр коммунист намын бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт орж улс төрийн товчоог халж, үйлдвэр, албан газрууд дахь намын салбар хороогоо татан буулгасан.

Мөн намыг зөвхөн засаг захиргааны нэгжээр зохион байгуулна, нам нь удирдах дээд байгууллага, төлөөллийн төв байгууллага, гүйцэтгэх төв байгууллага гэсэн бүтэцтэй байна. Улс төрийн нам 801-ээс доошгүй гишүүний бүртгэлтэй байх, энэ шаардлагыг хангасан намыг Улсын Дээд шүүх бүртгэж авна. Намын дүрэмд өөрчлөлт орвол 10 хоногийн дотор бүртгүүлнэ. Нам өөрөө өөрийгөө санхүүжүүлнэ, санхүүгийн тайлангаа Засгийн газарт тавина, гадаадын нам, иргэдээс Монгол улсын хууль тогтоомжийн дагуу хандив

¹ Ч.Гончигдорж. Улсын бага хурлын товчоон. (1990-1992 он)

² Улс төрийн намын тухай хууль. <https://legalinfo.mn/mn/detail/508>

авч болно. Авсан хандивын хэмжээг нийтэд мэдээлэхээр зохицуулсан. Хожим 1996 онд уг хуульд намыг УИХ дахь суудлын тоог жилд 1 сая төгрөгөөр тооцож улирал тутам төрөөс санхүүжүүлэх заалтыг нэмж өөрчилсөн. 2002 онд 1 сая төгрөгийг 10 сая төгрөг болгож нэмсэн байдаг. Өөрөөр хэлбэл, уг хуулийг үзэл баримтлал өөрчлөгдөж 1996 оноос эхлэн намд төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх болсон.

2005 онд Улс төрийн намын тухай хуулийг шинэчлэн найруулж, 5 бүлэг, 25 зүйл, 150 орчим заалттайгаар баталсан. Уг хуульд нийт 16 заалтыг 6 удаагийн нэмэлтээр өөрчилсөн байдаг. Гэвч судлаачдын дүгнэж байгаагаар 1990 оны БНМАУ-ын Улс төрийн намуудын тухай хуулийн үзэл баримтлал өөрчлөгдөөгүй, намын бүртгэл, хяналтын тогтолцоог сайжруулаагүй гэж үздэг. Тийм ч учраас хуулийг батлагдсан даруйгаас хуулийг шинэчлэх асуудлууд цаг ямагт яригдаж байсныг дурдах ёстой.

Хэдийгээр 2005 оны Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгад дотоод ардчилалтай байх, намын санхүү болон үйл ажиллагаа олон нийтэд ил тод байхыг зохицуулсан боловч уг шинэлэг заалтуудыг хэрэгжихгүй байсан. Хуулийг хэрэгжүүлэх хориглолтыг заалтууд нь бодит хөшүүрэг болох чадамжгүй, хяналт тавих байгууллага тодорхойгүй байсан.

1990, 2005 оны улс төрийн намын тухай хуулиудын үзэл баримтлал хуучирсан, хуулийн хэрэгжилт сул, нийгэм, улс төрийн хэрэгцээг хангаж чадахгүй байснаар дараах үр дагаврууд илэрч эхэлсэн.

1. Иргэд намд итгэхээ больсон.³
2. Намуудын үнэт зүйл, үзэл баримтлал тодорхойгүй болсон.⁴
3. Намуудыг үндэсний хэмжээнд нүсэр бүтэц, зохион байгуулахыг шахсан.⁵ Нам өөртөө тохирсон бүтцийг сонгох боломж олгоогүй.
4. Намын дэргэдэх байгууллагын эрх зүйн статус олон янз. Бусад хуулиудтай зөрчилдөж байсан.
5. Сонгуулийн насны иргэдийн 30 гаруй хувь намд гишүүнээр элссэн УДШ-ийн бүртгэлтэй болсон.⁶ Намуудын гишүүнчлэлийн бүртгэл шинэчлэгдэхгүй байсан.
6. Намын гишүүдийн ихэнх нь татвараа төлдөггүй.
7. Нам хүний эрх, жендерийн тэгш байдлын талаар бодлого, хөтөлбөргүй.
8. Хөгжлийн бэрхшээлтэй гишүүний улс төрийн оролцоог дэмжсэн, улс төрийн сонгох, сонгогдох эрхийг хангах бодлого хөтөлбөр байхгүй.⁷
9. Намын дотоод ардчилалд ахиц дэвшил гарахгүй

байсан⁸.

10. Намуудын хөрөнгө, орлого хаалттай болсон. Төр намуудад олгож байгаа санхүүгийн дэмжлэгийн зарцуулалтыг хянаж чадахгүй болсон.⁹
11. 1996 оноос хойш улс төрийн намуудад төрөөс олгосон санхүүгийн дэмжлэг тодорхойгүй.¹⁰
12. Улс төрийн намуудын санхүүжилт олон нийтэд ил тод бус, тайландаа аудит хийдэг эсэх нь тодорхойгүй байсан.¹¹
13. Намууд нам байгуулснаа бүртгүүлдэг, дүрэмд өөрчлөлт орвол бүртгүүлдэг, хяналт тавих тогтолцоо бүрдээгүй зэрэг хуулийн хэрэгжилт, зохицуулалт сул байсны үр дагаврууд илрэх болсон.

Тиймээс 2011, 2012, 2013, 2015, 2017, 2019 онуудад УИХ болон Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар дээр хэд хэдэн удаа хуулийн төсөл бичих ажлууд өрнөж байсан ч ахиц дэвшил гарахгүй байсан.

Үр дүнд нь улс төрийн нам, улс төрчид, улмаар төрд итгэх ард иргэд, олон нийтийн итгэл суларч, намыг үгүйсгэх, хамгийн итгэл муутай институци хэмээн үнэлэх хандлага нэмэгдсэн. Тухайлбал, бүр өмнөх 2014 он хүртэл 4 удаагийн "Азийн барометр" судалгаагаар Монгол Улсад улс төрийн намуудад итгэх итгэл жил ирэх бүр буурч сонгогчдын 80 гаруй хувь итгэхгүй байна гэж, "Сантмарал" сангийн 2017 оны судалгаанд оролцогчдын 81,3 хувь нь улс төрийн намууд олон нийтийн санаа бодлыг илэрхийлдэггүй, 44,3 хувь улс төрийн намууд байх хэрэггүй, 60,6 хувь нь улс төрийн намуудад итгэдэггүй гэж хариулсан байна. Мөн МЕС судалгааны байгууллагаас 2018 оны 2 дугаар сард хийсэн улс төрийн барометрийн түүвэр судалгаагаар оролцогчдын 64 хувь нь аливаа нэг улс төрийн намыг дэмжихгүй байна. Эдгээрээс хамгийн ноцтой Авлигатай тэмцэх газрын "Улс төрийн хүрэн дэх авлигын талаарх төсөөллийн судалгаа-2022"¹²-д дурдсанаар Монголын Улсын авлигын ерөнхий түвшинд нөлөөлсөн гол хүчин зүйлсийн нэгдүгээрт "Нийгэм, эдийн засгийн асуудал" (33.3%), хоёрдугаарт "улс төрийн нам, сонгуультай холбоотой" (31%) гэж дүгнэсэн байдаг.

Өөрөөр хэлбэл, намын эрх зүй нь улс төрийн шилжилтийг хурдасгах, шинэ нийгмийн хэрэгцээ, иргэдийн улс төрийн сонирхлыг дэмжсэн хариуцлагатай улс төрийн хүчин төлөвшихөд саад болсоор эдүгээ 33 жилийг өнгөрөөжээ. Тиймээс улс төрийн намуудын үйл ажиллагааг зохицуулсан эрх зүйн орчныг сайжруулах шинэчлэх нь нэн тулгамдсан асуудал болоод байна.

3 С.Мөнхбат. Улсын хэмжээнд судалгаанд оролцогчдын 80% нь аль нэг улс төрийн намд итгэхгүй байна. <https://ikon.mn/n/310c>

4 Д.Оюунхорол. Намууд боловсон хүчний бодлогоосоо эхэлж шинэчлэгдэх хэрэгтэй. <https://www.24tsag.mn/a/161035>

5 Дэлхийн намууд ба Монголын намууд. <https://www.24tsag.mn/a/153691>

6 Улс төрийн намуудын бүртгэл. УДШ. <https://www.supremecourt.mn/home?page=party&id=69&pr=63&tp=list>

7 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал: бодлого, үйл ажиллагаа. <https://mlsp.gov.mn/uploads/files/2300865ec1b737c21899a7ebc7db42da23523c9e.pdf>

8 Монголын улс төрийн намуудын дотоод ардчиллын индекс. 2020 он. <https://defacto.mn/wp-content/uploads/2021/07/210709>

9 Улс төрийн намуудын санхүүжилт, гишүүнчлэл, орон нутгийн сонгууль дахь улс төрийн намын оролцоог боловсронгуй болгох нь. https://forum.mn/uploads/site/1126/res_mat/2019/Судалгаа1_UNDP.pdf

10 Монголын улс төрийн намуудын санхүүжилтийн эрх зүйн орчин. АСДОУХ. 2018 он. <https://www.idea.int/sites/default/files/publications/political-finance-in-mongolia-MN.pdf>

11 Монголын улс төрийн намуудын санхүүжилтийн эрх зүйн орчин. АСДОУХ. 2018 он. <https://www.idea.int/sites/default/files/publications/political-finance-in-mongolia-MN.pdf>

12 Улс төрийн хүрэн дэх авлигын төсөөллийн судалгаа. https://cdn.greensoft.mn/uploads/site/1152/files/d8faf0f3-92d8-470f-bb01-c1b0b25490be/2019_uls%20tur.pdf

УЛС ТӨРИЙН НАМЫН ХУУЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ



Улсын төрийн
намыг

болгох, улсын хэмжээний бодлого дэвшүүлж
ажиллах



БОДЛОГЫН
НАМ



хүний эрх, эрх чөлөөг хамгаалах,
түүнд суурилсан үйл ажиллагааг
явуулах, жендэрийн эрх тэгш
байдлыг хангах, ЭМЭГТЭЙЧҮҮД,
ЗАЛУУЧУУД, АХМАД ҮЕ, ХӨГЖЛИЙН
БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭД зэрэг
нийгмийн сонирхлын бүлгүүдийн УЛС
ТӨРИЙН ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ,



Улс төрийн намыг
бүртгэх, түүний гишүүнд
элсэх, улмаар НИЙТ ҮЙЛ
АЖИЛЛАГААГ ЦАХИМ
ОРЧИНД ЯВУУЛАХ
орчныг бүрдүүлэх,

Хоёр. УЛС ТӨРИЙН НАМЫН ТУХАЙ ШИНЭ ХУУЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ


2023 онд шинэчлэн найруулсан Улс төрийн намын тухай хуулийн төслөөр Монгол Улсын Үндсэн хуулийн арван зургаадугаар зүйлийн 10-т заасны дагуу иргэдийн эвлэлдэн нэгдэх эрх, улс төрийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн баталгааг хангах зорилгоор улс төрийн нам үүсгэн байгуулах эрхтэй. Мөн 2019 оны Монгол Улс Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд Арван есдүгээр зүйлийн 1-д "Нам Үндсэн хуулийн арван зургаадугаар зүйлийн 10-т заасны дагуу байгуулагдаж, улсын хэмжээний бодлого дэвшүүлж ажиллана", "Намыг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэдийн нэг хувиас доошгүй тооны иргэд эвлэлдэн нэгдэж байгуулна", "Намын дотоод зохион байгуулалт ардчилсан зарчимд нийцсэн, хөрөнгө, орлогын эх үүсвэр, зарцуулалт нь нийтэд ил тод байна. Намын зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, санхүүжилт, төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх нөхцөлийг хуулиар тогтооно"¹³ гэж заасан.

Тиймээс Монгол Улсын Ерөнхийлөгч улс төрийн намуудтай зөвшилцөж, хуулийн үзэл баримтлалыг дараах байдлаар боловсруулсан. Үүнд:¹⁴

1. Улс төрийн намыг орчин үеийн олон ургалч ардчилсан засаглалын хөгжилт дэвшлийг харгалзан илүү өргөн цар хүрээнд тодорхойлох, Намын нийгэмд гүйцэтгэх үүрэг хариуцлага, нийт үйл ажиллагааны зарчмыг дэлхий нийтийн чиг хандлагад нийцүүлэх,
2. Улсын төрийн намыг "бодлогын нам" болгох, улсын хэмжээний бодлого дэвшүүлж ажиллах Үндсэн хуулийн нэмэлтийн үзэл санаа, эрх зүйн зохицуулалтыг хуульд шинээр тусгасан. Нам нь өөрийн улс төрийн үзэл баримтлал, үнэт зүйлдээ нийцсэн дүрэм, мөрийн хөтөлбөр, бодлого боловсруулж хэрэгжүүлэх,
3. Улс төрийн намын үзэл баримтлал, нийт бодлого үйл ажиллагааг ардчилсан зарчимд нийцүүлэн, хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, түүнд суурилсан үйл ажиллагааг явуулах, жендэрийн эрх тэгш байдлыг хангах, эмэгтэйчүүд, залуучууд, ахмад үе, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг нийгмийн сонирхлын бүлгүүдийн улс төрийн оролцоог нэмэгдүүлэх,
4. Улс төрийн намыг бүртгэх, түүний гишүүнд элсэх, улмаар нийт үйл ажиллагааг цахим орчинд явуулах орчныг бүрдүүлэх,
5. Улс төрийн намын санхүүжилтийн талаарх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй, бүрэн нээлттэй "шилэн" болгоно. Одоогийн төрийн болон төрийн бус холимог санхүүжилтийн зарчмыг хэвээр хадгалах боловч, хөрөнгө орлогын эх үүсвэр, зарцуулалт нь нийтэд ил тод болгож, төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх нөхцөл шалгуур, түүний мөнгөн

13 Монгол Улсын Үндсэн Хууль. 1992 он. <https://legalinfo.mn/mn/detail?lawid=367>


14 УИХ-д өргөн мэдүүлсэн Улс төрийн намын тухай хуулийн төсөл. <https://d.parliament.mn/tusul/3848c76b-3dd8-48a0-a34b-fc1f8c55d5a9>



Улс төрийн НАМЫН
САНХҮҮЖИЛТИЙН ТАЛААРХ эрх
зүйн зохицуулалтыг боловсронгуй,
БҮРЭН НЭЭЛТТЭЙ “ШИЛЭН”
БОЛГОНО.



сургалт, судалгаа хийх үүрэг
бүхий “СУДАЛГААНЫ ХҮРЭЭЛЭН”
улс төрийн намуудын дэргэд
ажиллуулах,



Аливаа шийдвэрийг гаргахдаа
намын ЖЕНДЭРИЙН ТЭГШ
БАЙДЛЫГ хангаж, гишүүдийн
оролцоог өргөжүүлэх

болон мөнгөн бус хэмжээ, хуваарилалт, шилэн санхүүжилтийн зарчим, зарцуулалтын зориулалтыг хуульд илүү нарийвчлан тусгах,

6. Улс төрийн намын бүртгэлийг Улсын Дээд Шүүх бүртгэж, хууль тогтоомжийн дагуу үйл ажиллагаа явуулж байгаа эсэх болон хөрөнгө санхүүгийн ил тод байдал, төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэгийн зарцуулалтын тайланд хяналт тавих, төрийн санхүүжилтийг олгох чиг үүргийг одоогийн Сонгуулийн төв байгууллагад хариуцах,

7. Улс төрийн намын бодлого, мөрийн хөтөлбөрийг боловсруулахад дэмжлэг туслалцаа үзүүлэх, сургалт, судалгаа хийх үүрэг бүхий “судалгааны хүрээлэн” улс төрийн намуудын дэргэд ажиллуулах, эдгээрийн үйл ажиллагааг төр тодорхой хэмжээнд дэмжин санхүүжүүлэх,

8. УИХ-ын ээлжит сонгуульд сүүлийн 8 (найман) жил нэр дэвшүүлж оролцоогүй нь улс төрийг намын үйл ажиллагааг түдгэлзүүлэх,

9. Улс төрийн нам нь дотоод үйл ажиллагаандаа олон ургалч ардчилсан зарчмыг тууштай хэрэгжүүлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгоно. Аливаа шийдвэрийг гаргахдаа намын жендэрийн тэгш байдлыг хангаж, гишүүдийн оролцоог өргөжүүлэх зэрэг зохицуулалтуудыг шинэчлэн тусгах зорилт тавьсан.

Гурав. УЛС ТӨРИЙН НАМЫН ТУХАЙ ШИНЭ ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТУУД

УДШ-д бүртгэлтэй улс төрийн 37 намын хүсэлт, шахалт, тэр дундаа УИХ-д суудалтай МАН, АН, ХҮН намуудын идэвхтэй манлайлын үр дүнд Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 7 бүлэг, 45 зүйлтэйгээр хэлэлцэж 2023 оны 7 сарын 7-ны өдөр баталсан.¹⁵

Хэлэлцүүлгийн явцад намуудаас олон санал ирж байсан ч, аль нэг намд тохирсон гэхээс илүү Монгол Улсад ардчилал, парламентын тогтолцоог бэхжүүлэх саналуудыг авсан. Зарим тусгай саналууд нь дээрх хуулийн үзэл баримтлалтай нийцээгүй тулд хуульд тусгагүй.



**БОДЛОГЫН НАМЫГ
ТӨЛӨВШҮҮЛЭХ НЬ**

Дэлхий даяар улс төрийн намыг тууштай бодлоготой байх, бодлого нь үнэт зүйл, үзэл баримтлал дээрээ тулгуурладаг байхыг чармайж байна. Тиймээс энэ хуульд намын уламжлалт тодорхойлолтыг өөрчилж, “Нам нь иргэдийн улс төрийн хүсэл зоригийг илэрхийлдэг, улсын хэмжээний бодлого дэвшүүлэн сонгуульд оролцдог, хамтын

15 Улс төрийн намын тухай хууль /шинэчилсэн найруулга/. 2023 он. <https://legalinfo.mn/mn/detail?lawid=16760239349461>

шийдвэр гаргаж, сайн дураараа эвлэлдэн нэгдсэн Монгол Улсын иргэдийн нэгдэл мөн" гэж тодорхойлсон. Мөн нам нь Үндсэн хуульт байгуулал, ардчилсан тогтолцооны зайлшгүй бүрэлдэхүүн хэсэг болохын хувьд иргэдийн улс төрийн хүсэл зориг, олон нийтийн үзэл бодлыг илэрхийлэх; төр, иргэдийн хооронд байнгын, тогтвортой, идэвхтэй холбоо харилцаа үүсгэх; иргэдийн улс төрийн боловсрол, идэвхтэй оролцоог хөхиүлэн дэмжих; төрийн улс төрийн алба хаах хариуцлагатай иргэнийг бэлтгэх; Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтөд оролцох; сонгуульд нэр дэвшүүлэн шударгаар өрсөлдөхийг анх удаа тодорхой зааж өгсөн.

Намыг байгуулах, бүртгүүлэх үйл явц нарийвчлан зааж, УДШ-д бүртгүүлнэ. Нам дотоод ардчилалтай байна, үйл ажиллагаандаа жендэрийн тэгш байдлыг хангана, гишүүдээ намын удирдах байгууллага, албан тушаал, сонгуульд нэр дэвших, сонгох, томилоход аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхахгүй байж, тэгш боломж олгоно. Удирдах дээд байгууллагыг бүрдүүлэхдээ нууц санал хураалт явуулж, гишүүдийн оролцоо, ил тод байдлыг хангаж, нэр дэвшүүлэхдээ аль нэг хүйсийн төлөөлөл 30 хувиас доошгүй байна. Намын дүрэм, хөтөлбөрийг батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах болон сонгуульд нэр дэвшигчийг санал болгоход намын гишүүдийн оролцоог хангаж, саналыг сонсоно. Нам бодлого, үйл ажиллагаандаа эмэгтэй, ахмад, залуу, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг нийгмийн сонирхлын бүлгүүдийн төлөөлөл, оролцоог хангаж ажиллана, хувь хүн болон нийгмийн бүлгийг аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхахыг хориглоно. Мөн намын үйл ажиллагаа дахь жендэрийн эрх тэгш байдлын талаарх тайланг Жендэрийн үндэсний хороонд хүргүүлнэ. Жендэрийн үндэсний хороо дүгнэлтээ жил бүрийн 08 дугаар сарын 01-ний өдрийн дотор сонгуулийн төв байгууллагад хүргүүлнэ. Сонгуулийн төв байгууллага уг дүгнэлтийг үндэслэн төрийн санхүүжилт олгох эсэхээ шийдвэрлэнэ.

Намын үйл ажиллагаагаа ил тод, нээлттэй явуулна. Нам өөрийн дүрэм, хөтөлбөр, бусад журам, санхүүгийн тайлан болон үйл ажиллагааны товч тайланг ил тод, нээлттэй байлгаж, нийтэд тогтмол мэдээлэх, мэдээлэл авах боломжоор хангана. Нам өөрийн бүх шатны байгууллагын хуралдаан, санал хураалт, сургалт, зөвлөгөөн, гишүүн элсүүлэх, гишүүний татвар хураах, хандив цуглуулах болон бусад ажиллагаа, нийгэмд болон гишүүдэд чиглэсэн арга хэмжээг аюулгүй байдлыг хангасан программ хангамж ашиглан намын дүрэмд заасны дагуу цахимаар явуулж болно. Нам цахим хуралдаан, санал хураалтыг зохион байгуулахдаа цахим системийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлыг хангах боломжит арга хэмжээг авах бөгөөд нууц санал хураалтыг цахимаар явуулсан тохиолдолд түүний нууцлалыг алдагдуулахгүй. Нам албан ёсоор нийтэд зарласан цахим хуудас, нийгмийн сүлжээний хаягтай бол тэдгээрийг Харилцаа холбооны зохицуулах хороо, сонгуулийн төв байгууллагад бүртгүүлнэ.

Намын бүтэц зохион байгуулалт нь гишүүдийн, эсхүл тэдгээрийн төлөөлөгчдийн хурал нь намын удирдах дээд байгууллага мөн бөгөөд түүнийг дөрвөн жилийн хугацаанд нэгээс доошгүй удаа хуралдуулна. Намын удирдах дээд байгууллагын эрх үүргийг тодорхой заасан. Удирдах дээд байгууллагын чөлөө цагт ажиллах намын төлөөллийн төв байгууллагатай байх бөгөөд түүнийг жил тутам нэгээс доошгүй удаа хуралдуулна. Төлөөллийн төв байгууллагын гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь санал гаргавал намын дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж болно. Энэ нэмэлт, өөрчлөлт нь намын дүрмийн гуравны нэгээс хэтрэхгүй байна. Намын дүрэмд заасны дагуу намын удирдах дээд байгууллага, эсхүл төлөөллийн төв байгууллага нь намын гүйцэтгэх төв байгууллагыг дөрвөн жилээс илүүгүй хугацаагаар сонгоно. Гүйцэтгэх төв байгууллага нь гурваас доошгүй тооны гишүүнтэй байна. Намын төлөөллийн төв байгууллага,



гүйцэтгэх төв байгууллага болон хяналтын байгууллагын бүрэлдэхүүнд аль нэг хүйсийн төлөөлөл 40 хувиас доошгүй байна. Мөн нам бодлого боловсруулахад зөвлөх, судалгаа хийх, намын гишүүдийг сургаж бэлтгэх, иргэдийн улс төрийн боловсролыг дэмжих үүрэг бүхий бодлогын судалгааны байгууллага намын дэргэд ажиллана.

Намын гишүүний эрхийг үйл ажиллагаанд тэгш эрхтэй оролцох; намын бүтцийн байгууллагад сонгох, сонгогдох; намын дүрэмд заасан бусад эрхтэй. Харин гишүүний үүргийг дүрэмд заасан татвар төлөх; хууль тогтоомж, намын дүрэмд захирагдах; намын дүрэмд заасан бусад үүргийг хүлээнэ.

Нам хуульд заасан үүргээ хэрэгжүүлээгүй, үйлд ажиллагаанд хориглосон заалтуудыг зөрчсөн тохиолдолд идэвхгүй хэлбэрт шилжүүлэх, эсвэл тараах арга хэмжээг авна. Намыг идэвхгүй болгох үндэслэл бүрдсэн тохиолдолд СЕХ УДШ-д мэдэгдэнэ. Мөн улс төрийн намыг зөвхөн удирдах дээд байгууллагын шийдвэрээр намыг өөрчлөн байгуулах, түүний үйл ажиллагааг зогсоох, эсхүл Улсын дээд шүүхийн шийдвэрээр намыг тараах замаар энэ хуульд заасны дагуу намыг татан буулгана. Мөн нам энэ хуульд заасны дагуу нийлэх, нэгдэх замаар өөрчлөн байгуулагдаж болох бөгөөд энэ тухай шийдвэрийг намын удирдах дээд байгууллага гаргаснаас хойш ажлын 10 өдрийн дотор Улсын дээд шүүхэд хүргүүлнэ.



БОДЛОГЫГ ДЭМЖСЭН САНХҮҮЖИЛТ

Намын орлого дараах эх үүсвэрийг төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэг; гишүүний татвар; хандив; намын өөрийн хөрөнгө, түүнээс олсон орлого; энэ хуулиар зөвшөөрсөн бусад орлого гэж зааж өгсөн.

Төрийн санхүүжилтийн 20-оос доошгүй хувийг эмэгтэй, ахмад, залуу, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг нийгмийн бүлгүүдийн улс төрийн оролцоог дэмжих, сургаж бэлтгэх;

15-аас доошгүй хувийг намын гишүүдийн болон иргэдийн улс төрийн боловсролыг дээшлүүлэх, ардчилал, хүний эрхийн үнэт зүйлийг нийтэд таниулах;

15-аас доошгүй хувийг намын хөтөлбөр, бодлого боловсруулахад чиглэсэн судалгаа хийх, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, намын дотоод ардчиллыг хөгжүүлэхэд зарцуулна. Дээр зардлыг гуравны нэгээс доошгүйг намын бодлогын судалгааны байгууллагын үйл ажиллагаанд зарцуулна. Мөн энэ хуульд улс төрийн намын орлогыг зөвхөн нэг банкны дансаар хүлээн авах бөгөөд өөр харилцах данстай байхыг хориглоно.

Намуудад төрөөс санхүүжилт олгохдоо Улсын Их Хурлын ээлжит, эсхүл ээлжит бус сонгуулиар сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн нийт сонгогчдын тоог нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 0.7 хувиар



Төрийн санхүүжилтийн 20-оос доошгүй хувийг эмэгтэй, ахмад, залуу, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг **НИЙГМИЙН БҮЛГҮҮДИЙН УЛС ТӨРИЙН ОРОЛЦООГ ДЭМЖИХ, СУРГАЖ БЭЛТГЭХ;**



15-аас доошгүй хувийг намын гишүүдийн болон иргэдийн **УЛС ТӨРИЙН БОЛОВСРОЛЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ,** ардчилал, хүний эрхийн үнэт зүйлийг нийтэд таниулах;



15-аас доошгүй хувийг намын хөтөлбөр, бодлого боловсруулахад чиглэсэн судалгаа хийх, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, **НАМЫН ДОТООД АРДЧИЛЛЫГ ХӨГЖҮҮЛЭХЭД ЗАРЦУУЛНА.**




улс төрийн **НАМЫН ОРЛОГЫГ ЗӨВХӨН НЭГ БАНКНЫ ДАНСААР ХҮЛЭЭН АВАХ** бөгөөд өөр харилцах данстай байхыг хориглоно.



**УЛСЫН ТӨСВӨӨС
НЭГ НАМД ОЛГОХ
САНХҮҮЖИЛТИЙН НИЙТ
ХЭМЖЭЭ НЬ:**




Тухайн намын
гишүүний татвар;



сонгуульт
гишүүний татвар;



иргэний өгсөн
хандив;



хуулийн
этгээдийн өгсөн
хандив

- ЫН ОРЛОГЫН НИЙЛБЭРЭЭС



хоёр дахин их,
эсхүл түүнээс
**ИЛҮҮ БАЙЖ
БОЛОХГҮЙ**

үржүүлснээс илүүгүй төгрөгийг улсын төсвөөс намуудад энэ хуульд заасны дагуу хуваарилна. Гэхдээ нийт сонгогчийн нэг ба түүнээс дээш хувийн санал авсан намд төрийн санхүүжилт олгоно. Төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэхдээ $H = /C1 \times T1/ + /C2 \times T2/$ томьёог хэрэглэнэ. "Н" гэж нийт сонгогчийн нэг ба түүнээс дээш хувийн дэмжлэг авсан намд хуваарилах нийт санхүүжилтийг; "C1" гэж Улсын Их Хурлын сонгуулиар тухайн намын авсан саналын тоог; "C2" гэж Улсын Их Хуралд тухайн намын авсан суудлын тоог; "T1" гэж нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 0.5 хувьтай тэнцэх хэмжээний төгрөгийг; "T2" гэж нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 25 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгийг жил бүр олгоно. Харин Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хууль тогтоомжид заасан нэр дэвшигчийн хүйсийн квотоос илүү нэр дэвшүүлсэн эмэгтэй улс төрчийн тоог болон хөгжлийн бэрхшээлтэй нэр дэвшигчийн тоог нэг суудлын дүнтэй тэнцэх санхүүжилтийг тухайн ээлжит сонгуулийн дараа зөвхөн нэг удаа олгохоор заасан.

- Улсын төсвөөс нэг намд олгох санхүүжилтийн нийт хэмжээ нь тухайн намын гишүүний татвар;
- сонгуульт гишүүний татвар;
- иргэний өгсөн хандив;

хуулийн этгээдийн өгсөн хандивын орлогын нийлбэрээс хоёр дахин их, эсхүл түүнээс илүү байж болохгүй гэж хязгаарласан. Хэрэв намыг идэвхгүйд тооцсон, татан буулгасан, эсхүл эвсэл тарсан бол энэ тухай шийдвэр хүчин төгөлдөр болсон өдрөөс тухайн нам, эвсэлд олгох төрийн санхүүжилтийг сонгуулийн төв байгууллага зогсооно.

Мөн нийт сонгогчийн нэг ба түүнээс дээш хувийн санал авсан нам төрөөс үзүүлэх шууд бус дэмжлэгийг дараах хэлбэрээр авах эрхтэй. Үүнд намын удирдах дээд байгууллагыг хуралдуулах, гишүүд, дэмжигчидтэй хийх уулзалт, хурал зохион байгуулах, иргэдийг мэдээллээр хангах, соён гэгээрүүлэх зорилгоор төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн уулзалтын танхим, хурлын заал, бусад танхимыг жилд нэг удаа үнэ төлбөргүй ашиглах; намын хөтөлбөр, үйл ажиллагааны талаарх нэвтрүүлгийг олон нийтийн радио, телевизээс гаргасан хуваарийн дагуу 30 минутаар улирал тутам үнэ төлбөргүй нэвтрүүлэх эдэлнэ. Энэ талаарх харилцааг хуульд тодорхой заасан.

Гишүүний татварын хэмжээ, бүрдүүлэлтийг тухайн намын дүрмээр тогтооно. Гэхдээ гишүүний сарын татварын хэмжээ нь нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 5 хувиас хэтрэхгүй байна. Сонгуульт гишүүний сарын татварын хэмжээ нь нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс хэтрэхгүй байна. Намын гишүүн зөвхөн өөрийн орлогоос төлнө. Нам дүрэм, журмаар намын гишүүний татварыг хөнгөлөх, чөлөөлөхөөр зохицуулж болно. Намын гүйцэтгэх төв байгууллага нь гишүүний татвар төлсөн баримтыг 10 жилийн хугацаанд архивлан хадгална.

Хандив нь мөнгөн болон мөнгөн бус хэлбэртэй байна. Иргэний болон хуулийн этгээдийн мөнгөн хандивыг зөвхөн данснаас дансанд шилжүүлэх хэлбэрээр намын дансанд хүлээн авах бөгөөд бэлэн мөнгөөр хандив авахыг хориглоно. Гишүүний татвар болон хандивыг нэг харилцах дансанд байршуулна. Дараах зүйл нь үнэ төлбөргүйгээр, эсхүл зах зээлийн дундаж ханшаас доогуур үнээр хийгдэж байгаа тохиолдолд мөнгөн бус хандивыг тодорхой заасан. Намд өгсөн хандивын хэмжээг уг нам, түүний салбар болон бүтцийн нэгжид өгсөн хандивын нийлбэр дүнгээр тооцно. Нэг жилд нэг иргэнээс авах хандивын дээд хэмжээ нь нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 12 дахин нэмэгдүүлсэн үнийн дүнгээс илүү байхыг хориглосон. Нэг жилд нэг хуулийн этгээдээс авах хандивын дээд хэмжээ нь нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 50 дахин нэмэгдүүлсэн үнийн дүнгээс хэтрэхгүй. Хуулийн этгээдийн намд өгсөн хандивын хэмжээг уг хуулийн этгээд, хуулийн этгээдийн хараат болон охин компани, салбар, төлөөлөгчийн газрын өгсөн хандивын нийлбэр дүнгээр тооцно. Намд өгсөн хандивын хэмжээг мөнгөн болон мөнгөн бус хандивын нийлбэр дүнгээр тооцно. Мөн хандивтай холбогдуулан хүлээх үүрэг, хориглох зүйлсийг сайтар зохицуулсан.



ИЛ ТОД БАЙДАЛ, ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГЫГ БҮРДҮҮЛЭХ

Улс төрийн намын үйл ажиллагаа, санхүүгийн ил тод байдлыг хангахын тулд санхүүгийн тайлан хагас жил тутам нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд нийцүүлэн тайлагнаж байхыг заасан. 36.9. Нам хандивыг сонгуулийн төв байгууллагаас баталсан бүртгэлийн маягтын дагуу цаасаар болон цахимаар бүртгэнэ. Намын санхүүгийн тайланд намын салбар болон бүтцийн нэгж, намын дэргэдэх бодлогын судалгааны байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэж, харьяа байгууллагын санхүүгийн мэдээллийг тусгана. Намын нэгдсэн тайланд намын төв байгууллагын тайланг доод шатны намын салбар нэгжийн тайлангийн хамт тус тус хавсаргана. Орон нутаг дахь салбар нэгжийн тайланд хандив өгсөн бүх хандивлагчийн ургийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, тус бүр өргөсөн хандивын хэмжээтэй хамт бичиж тусгана. Намын төв байгууллага энэ хандив болон хандивлагчийн жагсаалтыг нэгтгэж, авсан нийт хандивын хэмжээ, тодорхой нэг хандивлагчаас өргөсөн хандивын нийлбэр дүнг нэгтгэн гаргана. Сонгуулийн төв байгууллага намын санхүүгийн тайлан, түүнд холбогдох баримт бичгийг тухайн тайлант хугацаа дууссанаас хойш 10 жил хадгална.

Нам жилийн эцсийн санхүүгийн тайлангаа жил бүрийн 03 дугаар сарын 15-ны өдрийн дотор Аудитын тухай хуульд заасан шаардлагыг хангасан аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулан аудит хийсэн санхүүгийн тайланг сонгуулийн төв байгууллагад хүргүүлнэ. Аудитын хуулийн этгээд холбогдох баримт бичигтэй танилцах боломжийг нам бүрдүүлэх үүрэгтэй. Аудитын хуулийн этгээд намын санхүүгийн тайланг хянаад зөрчилтэй гэж үзвэл тайланг баталгаажуулахаас татгалзах эрхтэй бөгөөд энэ талаар

сонгуулийн төв байгууллагад ажлын гурван өдрийн дотор бичгээр мэдэгдэнэ. Алдаа, зөрчлийн тухай сонгуулийн төв байгууллагад мэдүүлсэн цаг мөчид тайланд алдаа, зөрчил агуулагдсан тухай олон нийт болон сонгуулийн төв байгууллага ямар нэгэн мэдээлэлгүй байсан, эсхүл хянах явцад алдаа, зөрчлийг илрүүлээгүй бөгөөд нам алдаа, зөрчлийг бүрэн хэмжээгээр ил тод болгож залруулсан бол энэ хуулийн 41, 42 дугаар зүйлд заасан эрх зүйн үр дагавар үүсэхгүй. Хууль бусаар олж авсан орлогыг сонгуулийн төв байгууллагад түүний тогтоосон хугацаанд нам шилжүүлэн өгнө. Хэрэв Нам санхүүгийн алдаа, зөрчлөө арилгаж, санхүүгийн тайлангаа шинэчлэн ирүүлээгүй бол сонгуулийн төв байгууллага тухайн намд энэ хуулийн 27.5-д заасан төрийн санхүүжилтийн /C1 x T1/ хэсгийг дараагийн жилд олгохгүй. Нам хууль бусаар авсан хандивыг хоёр дахин өсгөсөн дүнгээр сонгуулийн төв байгууллагад төлнө.

Сонгуулийн төв байгууллага жил бүрийн 05 дугаар сард багтаан намуудын санхүүгийн тайлан болон үйл ажиллагааны товч тайланг нэгтгэж, Улсын Их Хуралд мэдээлэх бөгөөд өөрийн цахим хуудсанд байршуулж, тухай бүр эмхэтгэж хэвлэн нийтэлнэ. Нам санхүүгийн тайлан болон үйл ажиллагааны товч тайлангаа сонгуулийн төв байгууллагад хүргүүлсэн өдрөөс хойш ажлын гурван өдрийн дотор өөрийн цахим хуудсанд байршуулж, цахим хуудасгүй намын тухайд өдөр тутмын хэвлэл мэдээллийн хэрэгсэлд нийтэлж, нийтэд танилцуулах үүрэгтэй. Цахим хуудсанд байршуулсан тайланг 10 жилийн хугацаанд устгахыг хориглосон.

ДҮГНЭЛТ



Улс төрийн намын тухай хуулийн шинэчлэх асуудал 2011 оноос хойш дөрвөн УИХ дамнан олон удаагийн өргөн хүрээнд намууд, гадаад, дотоодын судлаачид хэлэлцэж, санал шүүмжүүдийг авч сайжирч байсан нь хуулийг батлахад эергээр нөлөөлсөн.



Улс төрийн нам бол ялгаатай улс төрийн сонирхолтой бүлэг хүмүүс учир хуулийн төсөл дээр улс төрийн намуудад ялгаатай байр сууртай байсан. Гэхдээ нийтлэг бус сонирхолтой улс төрийн олон намууд хуулийн үзэл баримтлалыг дэмжиж байсан.



Улс төрийн намд итгэх иргэдийн итгэлийг сэргээх нь ардчилалд тустай тул аль нэг нам гэхгүйгээр бүх намууд ил тод, дотоод ардчилалтай, хариуцлагатай болж, бүх нийтийн хяналтад оролцохыг чухал гэж үзэж байсан.



1996 оноос эхэлж төрөөс намд санхүүгийн дэмжлэг олгож ирсэн. Энэ дэмжлэг нь шударга бус, давуу байдлыг хадгалахад нөлөөлж байсан. Нөгөө талаас намуудын санхүүжилт, түүний зарцуулалт хаалттай байсаар ирснийг намууд ил тод болгох, хариуцлагатай байхыг зөвшөөрч байсан.

Тиймээс улс төрийн намуудыг “Бодлогын нам” болж төлөвших, бодлогын судалгаа хийх, санхүүгийн дэмжлэг авах, тайлагнах, хариуцлага хүлээх тогтолцоог энэ хуулиар чиглүүлж өгсөн.



Намыг бүртгэх байгууллага дээр намууд ялгаатай байр суурьтай байсан тул сануудыг нэгтгэж УДШ бүртгэх зохицуулалтыг хэвээр үлдээж, Сонгуулийн төв байгууллага намын үйл ажиллагаа, санхүүжилтэд хяналт тавих эрхтэй болсон.



Улс төрийн намын тухай хууль 2024 оны 1 дүгээр сарын 01-нээс эхлэн хэрэгжиж эхэлж байна. Энэ хуулийг дагаж Шилэн дансны тухай хууль, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, Шүүхийн тухай хууль, Сонгуулийн төв байгууллагын тухай хуулиудад тус тус нэмэлт өөрчлөлт орсон.



Улс төрийн намууд уг хуулийг ойлгож, тууштай мөрдөж чадвал Монголын улс төрийн намууд бодлогын нам болж төлөвшиж олон нийтээс алдсан итгэлийг олж авах боломж бүрдэх юм. Энэ нь өнгөрсөн 30 гаруй жилийн улс төрийн алдааг зассан, дэлхий нийтийн хөгжлийн хадлагыг дагаж, монголын улс төрийн орчныг шинэчлэх, хариуцлагатай улс төрийн хүчин төлөвшихөд дэмжлэг болно гэдэгт илтгэлтэй байна.

Ашигласан ном

- Монгол Улсын Үндсэн хууль. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=367>
- Улс төрийн намын тухай хууль. 2005 он. <https://legalinfo.mn/mn/detail/508>
- Улс төрийн намын тухай хууль /шинэчилсэн найруулга/. 2023 он. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16760239349461>
- Ч.Гончигдорж. Улсын бага хурлын товчоон. (1990-1992 он)
- С.Мөнхбат. Улсын хэмжээнд судалгаанд оролцогсдын 80% нь аль нэг улс төрийн намд итгэхгүй байна. <https://ikon.mn/n/310c>
- Д.Оюунхорол. Намууд боловсон хүчний бодлогоосоо эхэлж шинэчлэгдэх хэрэгтэй. <https://www.24tsag.mn/a/161035>
- Дэлхийн намууд ба Монголын намууд. <https://www.24tsag.mn/a/153691>
- Улс төрийн намуудын бүртгэл. УДШ. <https://www.supremecourt.mn/home?page=party&id=69&pr=63&tp=list>
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал: бодлого, үйл ажиллагаа. <https://mlsp.gov.mn/uploads/files/2300865ec1b737c21899a7ebc7db42da23523c9e.pdf>
- Монголын улс төрийн намуудын дотоод ардчиллын индекс. 2020 он. <https://defacto.mn/wp-content/uploads/2021/07/210709>
- Улс төрийн намуудын санхүүжилт, гишүүнчлэл, орон нутгийн сонгууль дахь улс төрийн намын оролцоог боловсронгуй болгох нь. https://forum.mn/uploads/site/1126/res_mat/2019/Судалгаа1_UNDP.pdf
- Монголын улс төрийн намуудын санхүүжилтийн эрх зүйн орчин. АСДОУХ. 2018 он. <https://www.idea.int/sites/default/files/publications/political-finance-in-mongolia-MN.pdf>
- Монголын улс төрийн намуудын санхүүжилтийн эрх зүйн орчин. АСДОУХ. 2018 он. <https://www.idea.int/sites/default/files/publications/political-finance-in-mongolia-MN.pdf>
- Улс төрийн хүрэн дэх авлигын төсөөллийн судалгаа. https://cdn.greensoft.mn/uploads/site/1152/files/d8faf0f3-92d8-470f-bb01-c1b0b25490be/2019_uls%20tur.pdf

ASIAN ELECTORAL STAKEHOLDER FORUM - VI

Kathmandu Declaration on Strengthening Democracy and Promoting Electoral Integrity through Electoral Reforms in Asia



АЗИЙН СОНГУУЛИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ФОРУМ AESF VI

Д.ЭЛБЭРЭЛ

Сонгогчдын боловсрол төвийн төслийн менежер

2023 оны 12 сарын 6-7 ны өдрүүдэд Непал улсын Катманду хотноо 6 дахь удаагийн Азийн Сонгуулийн Байгууллагуудын Форум амжилттай зохион байгуулагдлаа. Форумд Азийн сонгуулийн төв байгууллагын төлөөлөл, сонгуулийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй төрийн бус байгууллагууд, ажиглагчдын бүлэг болон хэвлэл мэдээллийн төлөөлөл зэрэг 30-аад улс орны 300 гаруй төлөөлөгч оролцлоо. Форумгаар ардчиллыг бэхжүүлэх, чөлөөт, шударга сонгуулийг дэмжих талаар өөрсдийн туршлага, ололт, амжилт, алдаа оноог хэлэлцэн, цаашид баримтлан ажиллах "Катманду тунхаглал"-ыг боловсруулж, нэгдэж ажиллахаа амлалаа. Тус форумын үеэр оролцогчид нэгдэн "Улс төрд мөнгөний нөлөө", "Сонгууль болон ташаа мэдээлэл", "Сонгуульд нийгмийн бүлгүүдийн тэгш оролцоо", "Улс төрийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор санал авах үйл явцад тоног төхөөрөмж ашиглах нь", "Сонгуулийн шинэчлэлээр дамжуулан тогтвортой ардчиллыг дэмжих нь" болон "Байгаль орчинд үзүүлж буй сонгуулийн нөлөө" гэсэн 7 сэдвийн хүрээнд хэлэлцэж, өөрсдийн санал бодол, үйл ажиллагаа, зорилго, үр дүн, туршлага, асуудал бэрхшээл, ололт амжилтаа 7 өдрийн туршид хуваалцлаа.

Ардчилсан оролцоог сайжруулах нь: Ази дахь эмзэг болон бүх нийгмийн бүлгүүдийн тэгш оролцоог хангах нь



Сэдэв: Тогтвортой ардчилал болон
Сонгуулийн шинэчлэл



Сэдэв: "Ардчилсан оролцоог сайжруулах нь: Ази дахь эмзэг болон бүх нийгмийн бүлгүүдийн тэгш оролцоог хангах нь"

сэдэвт хэлэлцүүлгийн үеэр Сонгогчдын Боловсрол Төвийн Төслийн менежер Д.Элбэрэл "Сонгуульд эмэгтэйчүүд залуучуудын оролцоо, манлайлал" сэдвээр зочин илтгэгчээр оролцож, Монгол улсын сонгуулийн шинэчлэл болон залуучууд эмэгтэйчүүдийн оролцоо, амжилт, ололт, асуудал, бэрхшээлийн талаар танилцуулж хэлэлцүүлэг өрнүүллээ.

Тус форумыг Азийн Чөлөөт Шударга Сонгуулийн Сүлжээ /ANFREL/ нь Непал улсын Сонгуулийн Хороотой хамтран зохион байгууллаа. ANFREL нь Азийн ардчиллыг үндэсний болон бүс нутгийн түвшинд дэмжих зорилгоор 1997 оны 11-р сард байгуулагдсан. Азийн Чөлөөт Шударга Сонгуулийн Сүлжээ /ANFREL/ нь олон улсын сонгуулийн ажиглалтыг зохион байгуулах, өөрийн гишүүн байгууллагууд, тус улсын сонгууль ажиглах бүлэг, хэвлэл мэдээлэл болон сонгуулийн бусад оролцогч талуудад зориулан чадавх бэхжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлдэг. Азийн хэмжээнд тулгарч буй ардчилал болон сонгуулийн асуудлаар

нөлөөллийн ажил хийх чиглэлээр анхааран ажилладаг. Азийн Чөлөөт Шударга Сонгуулийн Сүлжээ нь одоогоор 18 улсын 28 гишүүн байгууллагатайгаар үйл ажиллагаагаа явуулж байна. Сонгогчдын Боловсрол Төв нь Азийн Чөлөөт Шударга Сонгуулийн Сүлжээний үндсэн гишүүдийн нэг бөгөөд одоогоор тус байгууллагын Удирдах Зөвлөлийн гишүүнээр 8 дахь жилдээ ажиллаж байна. Хоёр өдрийн турш үргэлжилсэн тус хэлэлцүүлгийн үр дүнд оролцогчид хамтран "Катманду тунхаглал" -ыг боловсруулан баталсан ба энэхүү тунхаглал нь "Банкок тунхаглал" 2012, "Дили Индикаторууд" 2015, "Бали амлалт" 2016, "Коломбо тангараг" 2018 болон 2021 оны цахимаар зохион байгуулагдсан AESF V-аар боловсруулагдсан "Ковидын дараах чөлөөт шударга сонгуулийн санамж бичиг"-ийн хэрэгжилтийг үнэлж, сайжруулсны үндсэн дээр боловсруулсан баримт бичиг юм. Дараагийн AESF хүртэл улс орнууд тус тунхаглалыг хэрэгжүүлэхэд онцгой анхааран ажиллахаа энэхүү форумын үеэр илэрхийлж байлаа.

СОНГУУЛИЙН ҮЕЭР ТҮГЭЭДЭГ ХУУРАМЧ МЭДЭЭЛЛИЙГ ТАНИХ НЬ

Сэтгүүл зүйн Инновац Хөгжлийн Үүр төв НҮТББ-ын дэргэдэх Монголын баримт шалгах төв, ерөнхий эрхлэгч
Э.БАТЦЭЦЭГ

Энэ онд дэлхийн 60 гаруй улсад том, жижиг сонгууль болно. Үүнтэй холбоотойгоор "хуурамч мэдээлэл ирэх хоёр жилийн хамгийн гол эрсдэл байх нь" гэж Дэлхийн эдийн засгийн форумаас гаргасан тайланд онцоллоо. Өнгөрсөн

2023 оны эрсдэлийн тайланд богино хугацааны 32 эрсдэлийг нэрлэснээс хуурамч мэдээлэл 16-д жагсаж байсан бол энэ жил ийнхүү "цойлж" орж ирлээ.

Figure C.

Global risks ranked by severity over the short and long term

**Please estimate the likely (severity) of the following risks over 2 year and 10 year period*



Дэлхийн улсуудын удирдагчид, эрдэмтэн мэргэд, эдийн засгийн экспертүүд цуглаж, ирэх жилүүдэд энэ цэнхэр гаригаа хэрхэн залуурдахаа хэлэлцдэг чуулганаар ийнхүү хуурамч мэдээллийг онцолсны учир юу вэ?

Учир нь,

- Хуурамч мэдээлэл ардчилсан сонгуульд сөргөөр нөлөөлдөг
- Хуурамч мэдээллээр хар пи-ар хийгсдийн зорилго хэрэв биелвээс улс орны цаашдын замналд хортой
- Хуурамч мэдээллийг хүлээн авч, итгэсэн, түүнд автаж сонголтоо хийсэн иргэд өөрсдөө энэхүү худал хуурмагийн гол золиос нь болдог

Тиймээс,

- Хуурамч, ташаа мэдээллийг таньж мэддэг, цааш түгээдэггүй
- Хуурамч мэдээлэл түгээх цаад зорилго, учир шалтгааныг ойлгодог
- Мэдлэгээ бусдадаа хуваалцдаг байх нь сонгогчдод олгосон эрхтэй нь дүйцэхүйц үүрэг юм.

Олон улсын баримт шалгах сүлжээ буюу IFCN-ий албан ёсны гишүүнээр Монголын баримт шалгах төв ажиллаж, шинэ тутам гарч буй хуурамч мэдээллийг шалгах арга зүйн сургалтад тогтмол хамрагдаж, автоматжуулалтын тусгай

эрх эзэмших зэргээр дэлхий нийтийн хуурамч мэдээллийн эсрэг үйл ажиллагаанд нэгэн түвшинд оролцож ирсэн. Энэ хүрээнд олж авсан мэдлэг, мэдээлэл, баримт шалгах арга зүйгээ олон нийтэд хуваалцах зарчим баримталж ажилладаг бөгөөд Европын сэтгүүлчдийн төвөөс саяхан гаргасан “Баримт шалгах гарын авлага” номыг орчуулан олон нийтийн хүртээл болгоод байгаа билээ.

Энэхүү номын хуурамч мэдээллийг түгээх учир шалтгаан болон хэрхэн нягтлах зарим аргаас хүргэе.




ХУДЛЫГ ИТГҮҮЛЭХИЙН ТУЛД БИШ, ТОГТОЛЦООГ ГАНХУУЛАХЫН ТӨЛӨӨ ХУУРАМЧ МЭДЭЭЛЭЛ ТҮГЭЭДЭГ

Ер нь хуурамч мэдээллийн зорилго нь түүндээ итгүүлэхийн тулд биш, харин олон нийтийг ямар ч мэдээлэлд итгэх итгэлгүй болгож, ардчиллын үнэ цэнийг бууруулах, дарангуйллын төрийг тогтоохын төлөө байдаг гэж олон улсад тодорхойлоод байна. Энэ нь сонгуулийн үеэр нэн илүүтэй илэрдэг.

Олон нийт авч буй мэдээлэлдээ шүүмжлэлтэй хандаж, хамгийн түрүүнд эргэлздэг байх нь чухал. Эргэлзээд цаашаа яах вэ, дэмий л үгүйсгэгч, хортой шүүмжлэгч байх уу, эсвэл тухайн эргэлзсэн мэдээллээ анхан шатны аргуудаар нягталж шалгаад, бодит үнэнийг олж чаддаг, түүнийгээ бусдадаа хуваалцдаг байх уу гэдгээ та өөрөө сонгоорой.

График.

Цахим мэдээллийн хэрэгслийн Фэйсбүүк хуудсаар олон нийтэд түгээсэн мэдээллийн зорилго (2020 оны ИТХ-ын болон 2021 оны ерөнхийлөгчийн сонгуулийн үеэр)



Хэвлэлийн Хүрээлэнгээс “Залуучууд, эмэгтэйчүүдийн сонгууль, улс төрийн оролцоог идэвхжүүлэх нь” хөтөлбөрийн хүрээнд “Орон нутгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгууль 2020, Ерөнхийлөгчийн сонгууль 2021” гэсэн судалгаа гаргажээ. Уг судалгаанд “цахим болон уламжлалт мэдээллийн хэрэгслээр сонгуулийн үеэр түгээсэн мэдээллийн дөнгөж 5% нь сонгогчийн боловсролд зориулсан контент байсан” гэжээ. Эсрэгээр, “нэр дэвшигч, намууд, эрх баригчдыг санаатайгаар гутаах, нэр хүндэд нь халдах”, эсвэл “хэтрүүлэн магтаж сурталчлах” нь түгээмэл байсан гэжээ.

Тэгвэл цахим орчинд буюу монголчуудын түгээмэл хэрэглэдэг Facebook платформд 2021 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн үеэр сонгогчийн боловсролд зориулсан мэдээлэл 3%-ийг эзэлж байсан гэдгийг судалгаанаас харж болно.



ХЭРХЭН ШАЛГАХ ВЭ?

Эрхэм сонгогч та одоо энэ хэсгийг уншихдаа гар утсаараа Facebook-т ороод эргэлзэж буй мэдээллээ хэрхэн шалгах аргыг дагаад хийгээд үзээрэй. Өндөр хандалт авдаг хамгийн түгээмэл хуурамч мэдээллийн жишээг авч үзье.


☑ Хаягийг шалгах энгийн арга

Ilona Aaron нэртэй хаягаас Ebarimt.mn зөвлөгөө гэдэг нэртэй группэд “Тэтгэвэрийг 2024 оны 01 дүгээр сарын 01-нээс нэмэх ёстой. Санал асуулга.1. Маш зөв нэмэх ёстой. 2. Нэмж болохгүй” гэсэн тайлбартай, мөнгөн дэвсгэрийн зурагтай пост оруулсан байна.

Ilona Aaron гэх хаягийн нэр дээр дарж ороход тухайн группэд оруулж байсан мэдээллүүд гарч ирнэ. Энд “Яг одоо 50,000,000 төгрөг аваарай. Миний messenger дээрх шууд зурваст “ок” гэж бичээрэй” гэсэн мэдээллийг хуваалцсан байна.

Харин түүний оруулсан постуудын дор Alvinne Sarah, Anne Chou, Eski Effet, Nicole Denise, Djäldø Bēīnčs гэх мэт гадны нэртэй хэрэглэгчид “зээл авах бол нууцаар чат бичээрэй” гэсэн сэтгэгдэл үлдээсэн байна.


Тэгвэл, View profile гэсэн товч дээр дарахад олон нийтэд нээлттэй оруулдаг мэдээллүүд нь гарч ирнэ. Энд нүүр зургаа сольсноор өөр ямар ч түүх байхгүй байна. Энэ шинж нь ямар нэг бодит хэрэглэгч биш, хуурамч мэдээллээр залилан хийх санаархалтай этгээдийн явуулж буй ажиллагааны хэсэг гэж ойлгох хэрэгтэй.



☑ Зургаар хайх хялбар арга

Та бүхэн шалгаж буй мэдээлэлдээ ашигласан зургийг скриншот хийж аваарай. Дараа нь Google Lens нэртэй аппликейшнд оруулж үзээрэй.

Шалгаж буй хаягийн нүүр зургийг энэ аргаар хайхад өндөр албан тушаалтай төрийн албан хаагчийн 2022 онд өгсөн ярилцлагад оруулсан зураг байна.




☑ Агуулгыг нягтлах болон учир шалтгааныг ойлгох арга

Ингээд, өөр хүний зураг ашиглан, хуурамч мэдээлэл түгээдэг хаяг байгааг мэдэж авлаа. Тэгвэл яах гэж тэтгэврээр далимдуулан санал авч, зээл олгох мэтээр төөрөгдүүлж, зөвхөн чатаар харилцахыг санал болгосон бэ гэдгийг бодож үзье.

Нэгдүгээрт, зөвхөн чатаар харилцах санал тавьсан л бол бүү итгэ. Учир нь олон нийтийн нүднээс далд таныг хуурахад хэн ч саад болж, үнэнийг нь хэлэхгүй. Тэнд таныг “зээл авах, эсвэл азтан болж бэлэн мөнгө авах болзол хангалаа” гэж хуураад регистрийн дугаар, утасны дугаар, гэрийн хаяг, дансны дугаар гэх мэт бүхий л хувийн мэдээллийг чинь анкет бөглүүлээд авна. Удалгүй таны дансан дахь мөнгийг авах, эсвэл хаягийг чинь орох боломжгүй болгох эрсдэл энд нээгдэж байна.

Мөн сонгогч таны үнэт саналыг авахыг оролдож, гэнэт хаанаас ч юм залгаад таны тойрогт нэр дэвшиж байгаа хүнийг магтах, саналаа өгөхийг ятгах, гэрийн чинь хаягаар ухуулах хуудас бүхий жижигхэн гарын бэлэг илгээхийг ч үгүйсгэхгүй.

Дараагийн хэсэгт хуурамч мэдээллийн хохирогч болохгүй ч идэвхжүүлснээр үүсэх эрсдэл, цахим платформуудын алгоритм яаж ажилладаг тухай мэдэж авцгаа.



АЛГОРИТМ ЯАЖ АЖИЛЛАДАГ ВЭ?

Монголчуудын дийлэнх нь хэрэглэдэг Facebook хэрхэн ажилладгийг тайлбарлая.

Бидний ихэнх нь Facebook хэрэглэхдээ сонирхол нэг хүмүүстэй найзалж, үзэл бодол, амьдралын хэвшил, хэмнэлээрээ ойролцоо хүмүүсийн постыг дэмжиж реакц дардаг, сэтгэгдэл үлдээдэг зэргээр идэвхжүүлж байдаг. Тиймээс өөрийн bubble буюу хөөсөн дунд нэг орчинг бүрдүүлж, түүндээ сэтгэл зүй, цаг заваа зориулан амьдардаг.

Сонгуулийн дараа саналаа өгөөгүй хүн нь ялагч болсныг хараад “миний мэдэх бүх хүн энэ нэр дэвшигчид саналаа өгөөгүй байхад гараад ирсэн байна, сонгууль будлиантай болсон, луйвардуулчихлаа” гэх мэтээр бичиж, зарим нь жагсаал, тэмцэлд уриалдгийг олон жишээнээс харсан байх. Тэр хүний зөв шүү дээ, өөртэйгээ ижилхэн хүмүүстэй “цахим гэр бүл” үүсгэсэн юм чинь найзуудынх нь ч дийлэнх нь адилхан сонголт хийсэн байх магадлалтай.


Тэгвэл, хуурамч мэдээлэл түгээгчид алгоритмын энэ шинж чанарыг ашигладаг. Дээр авсан жишээгээ үргэлжлүүлэе л дээ. Тэтгэврийг нэмэхийг дэмжиж саналаа өгөөд сэтгэгдэл үлдээсэн гэж бодъё. Тэгвэл алгоритм таныг



“энэ хаягаар түгээдэг мэдээллийг сонирхдог байх нь” гэж ойлгоод цаашид идэвхжүүлсэн хаягийн мэдээллийг танд үзүүлнэ. Мөн Facebook найзуудад чинь “таныг тэнд сэтгэгдэл үлдээжээ” гэдгийг харуулна. Магадгүй нэг найз чинь “энэ маань энд юу гээд биччихэв” гэж дарж орж үзэх байх. Энэ ганцхан хоромд тухайн мэдээллийг хичнээн хүн дамжуулан идэвхжүүлэхийг таашгүй.

Харин ингэж олон дагагч, идэвхжүүлэгч гишүүнтэй болсны дараа хүргэхийг хүссэн мэдээллээ түгээж эхэлдэг. Бидний авсан жишээ цахим залилангийн санаархалтай байх шинж чанартай ч энэ мэт хуурамч мэдээллээр идэвхжүүлсэн пэйж хаягуудыг өндөр үнээр зараад, дараагийн хаягийнхаа дагагчийг өсгөж, худалдахаар ажилладаг бүлэг байдгийг бас санаарай. Сонгуулийн өмнө олон хуудас, бүлгэмийн нэр өөрчлөгдөж, “250-500 мянган дагагчтай пэйж зарна” гэх мэт зар авж эхэлдэг нь үүний нотолгоо юм.

Хамгийн хортой нь үйл ажиллагаа, үзэл бодлоороо олон нийтийн дэмжлэг аваагүй хэн нэг нэр дэвшигч олон дагагчтай пэйж худалдаж аваад, түүгээрээ өөрийн мэдээллээ түгээж, сонгогчдыг хуурах боломжтой болгодог.



ухаанаар бүтээсэн эсэхийг нягталдаг хэд хэдэн сайтад оруулж үзээрэй. AI or Not, Hugging Face, Hive Moderation гэх мэт үнэгүй ашигладаг программ бий.



ХИЙМЭЛ ОЮУН УХААНЫ ЭРСДЭЛ, ТҮҮНИЙГ ХЭРХЭН ШАЛГАХ ВЭ?

Дэлхий нийтэд тулгамдаад байгаа хиймэл оюун ухааныг ашиглан хуурамч мэдээлэл түгээдэг үзэгдэл сонгуулийн үеийн бас нэг том эрсдэл юм. Хэнийг ч хэлээгүй үгийг нь “хэлүүлж”, хийгээгүй үйлдлийг нь “хийлгэж” бүтээх боломжтой тул сонгуулийн үеэр ямар “сюрприз” гарч ирэхийг төсөөлөхгүй байна.

Та бүхэн Ерөнхийлөгч хятадаар, УИХ-ын дарга испани хэлээр мэндчилгээ дэвшүүлж байгаа бичлэгийг үзсэн байх. Нэг кэйст нь эрүүгийн хэрэг үүсгээд шалгаж байна.

☑ Тэгвэл яаж шалгах вэ?

Хиймэл оюун ухаанаар хуурамч мэдээлэл бүтээгчдийг гүйцэж, урьдчилан сэргийлэх чадвар одоогоор дэлхийн баримт шалгагчдад байхгүй байна. Хойноос нь шалгах платформуудыг бүтээж, ямар шинж чанар нь хуурамч гэдгийг илтгэж байгааг олон нийтэд мэдээлэх байдлаар ажиллаж байна.

Та үзсэн зураг, бичлэгтээ эргэлзэж байвал хиймэл оюун

Энгийн нүдээр ажиглаж харахад хиймэл оюунаар бүтээсэн зургуудад хүний гар, хөлийн хуруу олон байх, эсвэл гажиг тогтоцтой байх гэх мэт алдаатай байсан. Харин сүүлийн үед энэ алдааг засаж сайжруулсан ба ихэнх тохиолдолд гарыг ил харагдахгүйгээр хийдэг болсон. Мөн бичлэгийг ажиглахад царай нь толигор, дүрс нь ихэнхдээ бүрсгэрдүү байх нь тийм ч чадварлаг бус хиймэл оюуныг ашиглан бүтээснийг харуулдаг. Бичлэгийг шалгахдаа аль нэг онцлог дүрслэл хэсгийг скриншот хийж аваад зураг шалгадаг аргаараа хайхад өмнө нь хаана ямар үед хийсэн бчилэг гэдгийг мэдэх боломжтой.

Илүү дэлгэрэнгүй мэдээллийг авч, өөрсдөө шалгаж туршиж үзмээр байвал Монголын баримт шалгах төвийн mfcc.mn сайтаас Хиймэл оюун ухаан гэж хайгаад ямар мэдээллийг хэрхэн шалгасныг сураарай.

Хуурамч мэдээлэлд автдаггүй, бодит байдлыг шалгаж мэддэг, түүнийгээ бусдадаа хуваалцдаг хариуцлагатай цахим хэрэглэгч байхыг хүсье.

Д.Гантулга: СУРГАЛТЫН ТӨГСГӨЛД НИЙТ СУРАГЧДЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ ҮНДСЭЭРЭЭ ӨӨРЧЛӨГДСӨН

Д.ГАНТУЛГА Дархан-Уул аймаг дахь сургагч багш
Д.АЛТАНЗУЛ Дархан-Уул аймаг дахь сургагч багш

Дархан-Уул аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэдэх Иргэний танхимын дарга Д.Гантулга, аймгийн ЗДТГ-ын Хууль, Эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн Д.Алтанзул нар НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөртэй хамтран “Шийдвэр гаргах түвшинд жендэрийн тэгш байдал, эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих нь” төслийн хүрээнд 2022-2024 онд хэрэгжүүлж буй “Хариуцлагатай сонгогч” хөтөлбөрийн сургагч багшийн сургалтад хамрагдаж, гэрчилгээ гардан авсан. Тус хөтөлбөрийн хүрээнд Дархан-Уул аймгийн залуучууд, тэр дундаа их, дээд сургуулийн оюутан залуус,

ЕБС-ын ахлах ангийн сурагчдад Сонгуулийн хууль тогтоомж, ач холбогдол, сонгуулийн эрх, үндсэн зарчмууд, үйл явц, мөрийн хөтөлбөр гэж юу болох, сонгуулийн сурталчилгааны хууль бус хэлбэрүүд, дүн шинжилгээ хийх чадварыг эзэмшүүлэх зэрэг зорилтот 6 удаагийн сургалтыг 2022-2023 онд амжилттай зохион байгууллаа. Сургалтад Дархан-Уул аймагт үйл ажиллагаа явуулдаг Анагаах ухааны коллеж, Уул уурхайн коллеж, Политехникийн коллеж, Дархан Өргөө МСҮТөв, ХААҮИС-ийн Дархан салбар сургуулийн оюутнууд, Ерөнхий боловсролын “Оюуны Ирээдүй” цогцолбор сургууль,





9 дүгээр сургуулийн ахлах ангийн сурагчид нийт 140 оюутан, сурагчид хамрагдсан.

Дархан-Уул аймаг нийт 108.000 хүн амтай. Үүнээс сонгуулийн насны 60 гаруй мянган иргэн байгаагаас 18-35 насны 25.000 залуучуудтай. Үүнээс гадна олон их дээд сургууль үйл ажиллагаа явуулдаг тул олон залуус ажиллаж, сурч, амьдардаг. Ганц Дархан-Уул аймаг гэлтгүй, улсын хэмжээнд сонгуульд саналаа өгөх залуусын идэвх оролцоо буурсаар байгаа энэ үед уг сургалт цагаа олсон арга хэмжээ болсон. Мөн аймгийн ЗДТГ, ГБХЗГ-ын сургалт хийх танхим, ширээ сандал, тоног төхөөрөмж, интернэт сүлжээ болон бусад хэрэгцээт зүйлээр ханган дэмжиж ажилласан. Аймгийн БШУГ, Их дээд сургуулиудын консерциум хамтран ажилласан юм.

Сургалтын үр дүнг товчхон дүгнэвэл сонгуулийн боловсрол, мэдлэг мэдээлэл зөвхөн залуучууд гэлтгүй бүх насныханд дутмаг байгаа нь ажиглагдлаа. Ихэнх залуучууд сонгууль зөвхөн ахмадуудад хамаатай гэж үздэг нь харагдсан. Бид сургалтын үндсэн хөтөлбөрүүдийг сурагчдад хүргэхээс гадна сонгуулийн хууль тогтоомж, сонгуулийн систем, түүний ялгаа, саналын хуудасны үлгэрчилсэн жишиг загвар гарган танилцуулж, сонгуулийн санал хураалтыг хэрхэн явуулдаг тухай бодит байдалд аль болох ойртуулсан тоглолтуудыг явуулсан нь тэдний сонирхлыг ихээхэн татаж байсан. Мөн бусад улсын сонгуулийн системийг жишээ татан тайлбарлаж, үүний үр дүнд сургалтын, сонгууль бол тэдний ирээдүйгээ шийдэх боломж гэдгийг ойлгосноо ярьж байлаа. Цаашид уг төслийг зөвхөн залуучууд гэлтгүй өргөн хүрээнд үргэлжлүүлэн хэрэгжүүлэх шаардлага байна гэж сургагч багшийн хувьд үзэж байна.

СОНГУУЛИЙН ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ ХАРЬЯАЛАЛ

1. Сонгуулийн хуулийг зөрчсөн тохиолдолд Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу дараах эрх бүхий албан тушаалтан зөрчлийг шалган шийдвэрлэнэ.



НЭГ. ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ШҮҮХ

/Зөрчлийн тухай хуулийн 17.1 дүгээр зүйлийн 7, 16, 18.1, 18.2, 18.4, 23 дахь хэсэгт заасан зөрчил/

7.Нэр дэвшигчийн нэр төр, алдар хүндийг гутаан доромжилсон худал мэдээллийг нийтэд тараасан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

16.Хүн, хуулийн этгээд нь ээлжит сонгуулийн жил эхэлснээс хойш санал авах өдрийг дуустал, эсхүл нөхөн болон ээлжит бус сонгууль товлон зарласан шийдвэр гарснаас хойш санал авах өдрийг дуустал сонгогчдын саналыг татах зорилгоор:

16.1.бараа, эд зүйл хөнгөлөлттэй үнээр худалдсан, аливаа үйлчилгээг хөнгөлөлттэй болон төлбөргүйгээр үзүүлсэн;

16.2.нийтийг хамарсан биеийн тамирын уралдаан, тэмцээн, баяр наадам, урлагийн тоглолт, хүлээн авалт, дайллаа, цайллаа, хонжворт сугалаа зохион байгуулсан, ивээн тэтгэсэн;

16.3.сонгогчдыг гадаад, дотоодод аялал зохион байгуулан оролцуулсан, амралт, сувилалд амраасан, сувилуулсан;

16.4.ирээдүйд өөрийн болон бусдын хөрөнгөөр мөнгө, эд бараа өгөхөөр гэрээ байгуулсан, хэлцэл хийсэн;

16.5.хишиг, хувь, хувьцаа өгөх, ажлын байранд зуучлах, ажилд оруулах зэргээр бусдад давуу байдал олгосон, амлалт өгсөн;

16.6.сонгуульд оролцохоос татгалзахыг болон сонгуулийн хууль тогтоомж зөрчихийг уриалсан агуулга бүхий сурталчилгаа явуулсан;

16.7.харилцаа холбоо болон хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим орчин ашиглан улс төрийн чансаа тогтоох зорилго бүхий аливаа хэлбэрийн шалгаруулалт, санал асуулга зохион байгуулсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

18.Сонгуулийн сурталчилгаа явуулах эрх бүхий этгээд нь сонгуулийн сурталчилгааны явцад:

18.1.хуульд зааснаас өөр арга, хэлбэрээр сонгуулийн сурталчилгаа явуулсан;

18.2.зөвшөөрснөөс бусад хугацаанд сонгуулийн сурталчилгаа хийсэн;

18.4.нам, эвслийн нэр дэвшигч нь тухайн нам, эвслийн мөрийн хөтөлбөрөөс тусдаа мөрийн хөтөлбөр гаргаж ашигласан;

23.Хандив өгөхийг хориглосон этгээдээс өгсөн хандивыг буцаан шилжүүлээгүй бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.



ХОЁР. ТАГНУУЛЫН БАЙГУУЛЛАГЫН ЭРХ БҮХИЙ АЖИЛТАН

/Зөрчлийн тухай хуулийн 17.1 дүгээр зүйлийн 35, 36 дахь хэсэгт заасан зөрчил/

35.Санал хураалтын дүн, сонгуулийн баримт бичгийг эрх бүхий байгууллагад хүргүүлэх, дамжуулахад саад учруулсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

36.Сонгуулийн автоматжуулсан системийг ашиглан явуулж байгаа мэдээллийн ажиллагаанд хуулиар эрх олгогдоогүй хүн, хуулийн этгээд хөндлөнгөөс оролцсон нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Тайлбар: Энэ зүйлд заасан Сонгуулийн хууль гэдэгт Сонгуулийн автоматжуулсан системийн тухай, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийг ойлгоно.



**ГУРАВ.
ЦАГДААГИЙН
БАЙГУУЛЛАГЫН ЭРХ
БҮХИЙ АЛБА ХААГЧ**

/Зөрчлийн тухай
хуулийн 17.1 дүгээр
зүйлийн 1, 2, 3, 5, 6, 9,
10, 11, 12, 13, 15, 18.3,
18.5, 18.6, 18.7, 28, 29,
30, 31, 32, 33, 34 дэх
хэсэгт заасан зөрчил/

1.Хүн, хуулийн этгээд нь сонгуулийн хорооноос мэдээлсэн санал хураалтын урьдчилсан дүнг илтэд гуйвуулсан, өөрөөр мэдээлсэн, мэдэгдэл хийсэн бол хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2.Сонгуулийн ажилд туслалцаа үзүүлэх, эсхүл сонгуулийн хорооны ажиллах байр, санал авах байрыг үнэ төлбөргүй гаргаж өгөх үүргээ биелүүлээгүй бол хүнийг дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

3.Сонгуулийн уулзалт, хурал, цуглаан хийхэд зориулж өөрийн эзэмшиж байгаа соёлын төв, биеийн тамирын болон хурлын заал, бусад байр, танхимыг үнэ төлбөргүй ашиглуулах үүргээ биелүүлээгүй бол хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

5.Нэр дэвшигчээр бүртгэх тухай шийдвэр гарснаас хойш нэр дэвшигчээр бүртгэгдсэн этгээд нэр дэвшихээс татгалзсан бол хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

6.Бие даан нэр дэвшигчид нэгдэж сонгууль эрхэлсэн байгууллага байгуулсан бол хүнийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

9.Сонгуулийн сурталчилгаанд тээврийн хэрэгсэл ашиглах журмыг зөрчсөн бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

10.Ухуулах хуудсыг байршуулахдаа цавуу, цавуулаг эд зүйл ашиглан тогтоож гудамж талбай, орчныг бохирдуулсан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

11.Намын далбаа, уриа, таних тэмдгийг байрлуулахыг хориглосон газарт байрлуулсан бол хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

12.Сонгуулийн сурталчилгаанд радио, телевиз ашиглах талаар хуулиар тогтоосон журам зөрчсөн бол хуулийн этгээдийг нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

13.Сонгуулийн сурталчилгаанд хуульд заасны дагуу бүртгүүлээгүй цахим хуудас ашигласан, эсхүл бусдын нэр болон хуурамч цахим хаяг ашигласан бол хүнийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

15.Эрх бүхий байгууллагаас баталсан цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах, түүнд хяналт тавих журам зөрчсөн бол хүнийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

18.Сонгуулийн сурталчилгаа явуулах эрх бүхий этгээд нь сонгуулийн сурталчилгааны явцад:

18.3.сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгагдаагүй аливаа зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх талаар амлалт өгсөн, ийм агуулга бүхий аливаа үйлдлийг сонгуулийн сурталчилгаанд ашигласан;

18.5.хуульд зааснаас бусад тохиолдолд төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн тээврийн хэрэгсэл, бусад өмч хөрөнгийг аливаа хэлбэрээр сонгуулийн сурталчилгаанд ашигласан;

18.6.чанга яригч ашиглан оройн 22:00 цагаас дараа өдрийн 08:00 цаг хүртэлх хугацаанд сонгуулийн сурталчилгаа явуулж, бусдын амгалан тайван байдлыг алдагдуулсан;

18.7.аливаа шашны зан үйл ашигласан, түүнийг зохион байгуулсан, оролцсон, ивээн тэтгэсэн, шашны холбогдолтой эд зүйл тараасан бол хүнийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

28.Сонгуулийн хуульд заасан итгэмжилсэн иргэн хоёроос дээш сонгогчид туслалцаа үзүүлсэн бол хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

29.Нэр дэвшигч, ажиглагч, улс төрийн албан тушаалтан итгэмжилсэн иргэний үүргийг гүйцэтгэсэн бол хүнийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

30.Сонгогч нь:

30.1.санал авах байрнаас саналын хуудас авч гарсан;

30.2.саналын хуудсанд тэмдэглэсэн саналаа болон бусад сонгогчийн тэмдэглэсэн

саналыг баримтжуулан зураг авсан, дүрс бичлэг хийсэн, шууд дамжуулсан, бусдад харуулсан;

30.3.саналын хуудсанд зориулалтын бус үзгээр санал тэмдэглэсэн;

30.4.аль нэг нэр дэвшигчийн төлөө санал өгөх, эсхүл өгөхгүй байхаар мөнгө, эд зүйл шаардсан, шаардаж авсан бол хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

31.Санал авах өдөр ажиллаж байгаа сонгогчийг санал өгөх боломжоор хангах үүргээ биелүүлээгүй бол хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

32.Сонгуулийн сурталчилгаа явуулах эрх бүхий этгээд болон ажиглагч нь сонгуулийн хорооны ажиллах байр болон санал авах байранд сонгуулийн сурталчилгаа, түүнтэй холбоотой үйл ажиллагаа явуулсан бол хүнийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний

төгрөгөөр, хуулийн этгээдийг тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

33.Ажиглагч хуульд заагаагүй эрх эдлүүлэхийг шаардах, хүч хэрэглэх, айлган сүрдүүлэх, худал мэдээлэл нийтэд тараах зэрэг хууль бус арга хэрэглэсэн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

34.Санал авах өдөр:

34.1.сонгууруулах ундаагаар үйлчилсэн, худалдан борлуулсан;

34.2.олон нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулсан;

34.3.гадаа болон битүү талбайд худалдаа, үйлчилгээний төв ажиллуулсан бол хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.



ДӨРӨВ. ТАТВАРЫН УЛСЫН БАЙЦААГЧ

/Зөрчлийн тухай
хуулийн 17.1 дүгээр
зүйлийн 21, 22, 24 дэх
хэсэгт заасан зөрчил/

21.Сонгуулийн зардлын дансыг бүртгүүлэх, зардлын дансанд мөнгөн хөрөнгийг төвлөрүүлж, зарцуулах талаар хуульд заасан журмыг зөрчсөн бол хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

22.Хуульд заасан хэмжээнээс хэтрүүлж нам, эвсэлд, эсхүл нэр дэвшигчид хандив өгсөн, эсхүл тухайн намын нэгдэн орсон эвсэлд давхардуулан хандив өгсөн бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

24.Мөнгөн бус хандив өгөх талаар хуулиар тогтоосон журмыг зөрчсөн бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.



ТАВ. ШУДАРГА ӨРСӨЛДӨӨН, ХЭРЭГЛЭГЧИЙН ТӨЛӨӨ ГАЗРЫН УЛСЫН БАЙЦААГЧ

/Зөрчлийн тухай
хуулийн 17.1 дүгээр
зүйлийн 8, 16.7, 19 дэх
хэсэгт заасан зөрчил/

8.Сонгуулийн сурталчилгаа явуулсан хэвлэл мэдээллийн байгууллага сонгуулийн сурталчилгаа дууссан өдрөөс хойш 10 хоногийн дотор сурталчилгаа явуулсан талаарх тайланг нийтэд мэдээлэх үүргээ биелүүлээгүй бол хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

16.Хүн, хуулийн этгээд нь ээлжит сонгуулийн жил эхэлснээс хойш санал авах өдрийг дуустал, эсхүл нөхөн болон ээлжит бус сонгууль товлон зарласан шийдвэр гарснаас хойш санал авах өдрийг дуустал сонгогчдын саналыг татах зорилгоор:

16.7.харилцаа холбоо болон хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим орчин ашиглан улс төрийн чансаа тогтоох зорилго бүхий аливаа хэлбэрийн шалгаруулалт, санал

асуулга зохион байгуулсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

19.Хэвлэл мэдээллийн байгууллага сонгуулийн сурталчилгааны үеэр аль нэг нам, эвсэл, нэр дэвшигчийн талаарх мэдээ, мэдээллийг дагнан гаргасан, эсхүл гаргахгүй байхаар амлалт авсан, гэрээ байгуулсан бол хүнийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.



ЗУРГАА. МОНГОЛ БАНКНЫ ХЯНАН ШАЛГАГЧ

/Зөрчлийн тухай
хуулийн 17.1 дүгээр
зүйлийн 26 дахь хэсэгт
заасан зөрчил/

26. Сонгуулийн зардлын данс байршуулсан банк сонгуулийн санал авах ажиллагаа дууссан өдрөөс хойш 30 хоногийн дотор нам, эвсэл, нэр дэвшигчийн дансны гүйлгээний мэдээллийг төрийн аудитын дээд байгууллагад хүргүүлэх үүргээ биелүүлээгүй бол хүнийг дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.



ДОЛОО. УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЯНАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧ

/Зөрчлийн тухай хуулийн 17.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан зөрчил/

4. Хуульд зааснаас бусад тохиолдолд сонгогчдын нэрийн жагсаалтыг олшруулсан, эсхүл тараасан бол хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.



НАЙМ. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ /САНГИЙН ЯАМ/

/Зөрчлийн тухай
хуулийн 17.1 дүгээр
зүйлийн 25, 27 дахь
хэсэгт заасан зөрчил/

25. Нам, эвсэл, нэр дэвшигч нь сонгуулийн зардлын тайлангаа хуульд заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хүргүүлэх үүргээ биелүүлээгүй бол хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

27. Нэр дэвшигч, нам, эвсэл хандив болон сонгуулийн зардлын зарцуулалтын явцын тайланг санал авах өдрөөс 3 хоногийн өмнө нийтэд ил тод мэдээлж, төрийн аудитын байгууллагад хүргүүлэх үүргээ биелүүлээгүй бол хүнийг хорин мянган нэгжтэй тэнцэх төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.



ЕС. ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ХЯНАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧ /ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМ/

/Зөрчлийн тухай
хуулийн 17.1 дүгээр
зүйлийн 14, 15, 17, 20
дахь хэсэгт заасан
зөрчил/

14. Үүрэн холбооны болон интернетийн үйлчилгээ эрхлэгч нь эрх бүхий байгууллагын шийдвэрт заасан зөрчил гаргасан цахим хуудас болон тухайн мэдээ, мэдээллийг өөрийн сүлжээнд хаагаагүй бол хүнийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

15. Эрх бүхий байгууллагаас баталсан цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах, түүнд хяналт тавих журам зөрчсөн бол хүнийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

17. Сонгуулийн сурталчилгаа явуулах эрх бүхий этгээдээс бусад этгээд сонгуулийн сурталчилгаа хийсэн бол хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

20. Нам, эвслийн дарга, түүнчлэн нэр дэвшигч нь сонгуулийн сурталчилгаа эхэлсэн өдрөөс хойш санал авах ажиллагаа дуустал сонгуулийн сурталчилгааны бус бие даасан нэвтрүүлэг, хөтөлбөр, ярилцлагад оролцсон, эсхүл сонгуулийн сурталчилгаа эхлэхээс өмнө хийгдсэн аливаа нэвтрүүлэг, хөтөлбөр, дуу, дүрс бичлэг, ярилцлагыг нэвтрүүлсэн, нийтэлсэн бол хүнийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2. Улс төрийн намын тухай хуулийг зөрчсөн тохиолдолд Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу дараах эрх бүхий албан тушаалтан зөрчлийг шалган шийдвэрлэнэ.



НЭГ. ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ШҮҮХ /ЗӨРЧИЙН ТУХАЙ ХУУЛИЙН 17.2 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсэгт заасан зөрчил/

3.Монгол Улсын иргэд нам үүсгэн байгуулахад дарамт, шахалт үзүүлэх, хөндлөнгөөс оролцсон бол хүнийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

4.Намын хяналтын байгууллагын хараат бус байдалд хөндлөнгөөс нөлөөлөхийг оролдсон бол хүнийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.



ХОЁР. УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЯНАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧ

/Зөрчлийн тухай хуулийн 17.2 дугаар зүйлийн 9 дэх хэсэгт заасан зөрчил/

9.Намаас бусад хуулийн этгээд нам гэсэн оноосон нэр хэрэглэсэн бол хүнийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.



ГУРАВ. СОНГУУЛИЙН ТӨВ БАЙГУУЛЛАГЫН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН

/Зөрчлийн тухай хуулийн 17.2 дугаар зүйлийн 1, 2, 5, 6, 7, 8 дахь хэсэгт заасан зөрчил/

1.Нам нь Улс төрийн намын тухай хуулийн 10.1.6-д заасан хориглолтыг зөрчиж мөнгөн хөрөнгө авсан бол тухайн мөнгөн дүнг хоёр дахин үржүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2.Нам нь Улс төрийн намын тухай хуулийн 10.1.6-д заасан хориглолтыг зөрчиж мөнгөн бус хөрөнгө, эсхүл үйлчилгээ авсан бол хууль бусаар авсан хөрөнгө, орлогыг хурааж хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

5.Нам хуульд заасны дагуу өөрчлөн байгуулагдсан тохиолдолд түүний өмч, хөрөнгийг тус намын гишүүн болон бусад иргэн, хуулийн этгээд аливаа хэлбэрээр өмчлөх, үргэлжлүүлэн хэрэглэсэн бол хүнийг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр,

хуулийн этгээдийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

6.Нам нь Улс төрийн намын тухай хуулийн 26.1-д заасан орлогыг банкны нэг дансаар хүлээн аваагүй бол тухайн орлогын мөнгөн дүнг хоёр дахин үржүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

7.Нам нь иргэний болон хуулийн этгээдийн хандивыг бэлэн мөнгөөр хүлээн авсан бол тухайн мөнгөн дүнг хоёр дахин үржүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

8.Нам нь нэг жилд нэг иргэн, хуулийн этгээдээс авах хандивын дээд хэмжээг хуульд зааснаас хэтрүүлэн авсан бол тухайн хандивын мөнгөн дүнг хоёр дахин үржүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

- “Зөрчил шалган шийдвэрлэх” гэж зөрчлийн хэрэг бүртгэлт, түүнд тавих прокурорын хяналт, зөрчил шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагааг, “зөрчлийн хэрэг бүртгэлт” гэж зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдийг тогтоох, шийтгэл оногдуулах эсэхийг шийдвэрлэх зорилгоор эрх бүхий албан тушаалтны явуулах энэ хуульд заасан ажиллагааг явуулахыг ойлгоно.

/Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.4 дүгээр зүйлийн 1.1, 1.2 дахь хэсэг/

- Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг уг зөрчил үйлдэгдсэн нутаг дэвсгэр, энэ хуульд заасан харьяаллын дагуу явуулна.

/Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэг/

- Прокурор зөрчлийн хэрэг бүртгэлт хуулийн хүрээнд явагдаж байгаа эсэхэд хяналт тавих, илэрсэн зөрчлийг арилгуулах талаар эрх бүхий байгууллагад шаардлага хүргүүлэх ба зөрчлийг хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд оролцоно.

/Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 2.2 дугаар зүйлийн 1.1, 1.7, 1.16 дахь хэсэг, Прокурорын тухай хуулийн 11 дүгээр зүйл, 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэг/



Ээлжит сонгуулийн жил эхэлснээс хойш санал хурааж дуустал аливаа этгээд

СОНГОГЧДЫН САНАЛЫГ ТАТАХ

зорилгоор дараах үйлдэл, үйл ажиллагаа явуулахыг

ХОРИГЛОНО!

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг



Мөнгө, эд зүйл тараах, бараа, эд зүйл хөнгөлөлттэй үнээр худалдах, аливаа үйлчилгээ төлбөргүйгээр болон хөнгөлөлттэй үзүүлэх



Сонгуульд оролцохоос татгалзахыг болон сонгуулийн хууль тогтоомж зөрчихийг уриалсан агуулга бүхий сурталчилгаа явуулах



Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим орчин, мессеж ашиглан улс төрийн чансаа тогтоох зорилго бүхий аливаа хэлбэрийн шалгаруулалт, санал асуулга зохион байгуулах, нийтлэх



Тухайн жилийн төсөвт тусгаагүй нийгмийн халамж, хамгааллын хөтөлбөр хэрэгжүүлэх, амлалт өгөх, зарлах



Хишиг, хувь, хувьцаа өгөх, ажлын байранд зуучлах, ажилд оруулах зэрэг амлалт өгөх



Нийтийг хамарсан биеийн тамирын уралдаан, тэмцээн, баяр наадам, урлагийн тоглолт, хүлээн авалт, дайллага, цайллага, төлбөрт таавар, бооцоот, мөрийтэй тоглоом зохион байгуулах, ивээн тэтгэх



Ирээдүйд өөрийн болон бусдын хөрөнгөөр мөнгө, эд бараа өгөхөөр гэрээ байгуулах, хэлцэл хийх



Сонгогчдыг гадаад, дотоодод аялал зохион байгуулан оролцуулах, амралт, сувилалд амраах, сувилуулах

Сонгогчид бэлэн мөнгө, эд зүйл тараасныг сонгогч баримттайгаар цагдаагийн байгууллагад мэдэгдэж болно.

Сонгогчид хууль бусаар мөнгө, эд зүйл тараасан болох нь тогтоогдсон бол мэдээлэл гаргасан иргэн тараасан бэлэн мөнгө болон эд барааны үнийн дүнг арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг гэм буруутай этгээдээс гаргуулахаар шаардах эрхтэй.



ДЭЛХИЙН УЛС ОРНУУДЫН 2024 ОНД ЗОХИОН БАЙГУУЛАХ СОНГУУЛИЙН ХУАНЛИ

2024 ОН: ТҮҮХЭН ДЭХ ХАМГИЙН ТОМ СОНГУУЛИЙН ЖИЛ

2024 онд дэлхийн 60 гаруй оронд үндэсний сонгууль болох гэж байгааг статистикийн судалгаагаар гаргажээ. Энэ жил дэлхийн нийт хүн амын дөрөвний нэг буюу 2 тэрбум гаруй сонгогч сонгуулийн санал хураалтад оролцох төлөвтэй байгааг судлаачид онцолсон байна. 2024 оныг супер сонгуулийн жил, эсвэл түүхэн дэх хамгийн том сонгуулийн

жил гэж нэрлэсэн бөгөөд энэ жил болох АНУ, Мексик, Энэтхэг, Индонез зэрэг хүн ам ихтэй орнуудын сонгууль судлаач, шинжээчдийн анхаарлыг татаж байна.

Уншигч Та бүхэнд Дэлхийн Сонгуулийн байгууллагуудын холбооноос /A-Web/ гаргасан 2024 онд зохион байгуулагдах сонгуулийн хуанлиг танилцуулъя.


UIN.MN
СУДАЛГААНЫ САН



Бутан

Сонгуулийн төрөл: Үндэсний ассамблейн сонгууль


Нэгдүгээр сарын 09



Тайвань

Сонгуулийн төрөл: Ерөнхийлөгчийн сонгууль

Нэгдүгээр сарын 13



Комор

Сонгуулийн төрөл: Ерөнхийлөгчийн сонгууль

Нэгдүгээр сарын 14



Финланд

Сонгуулийн төрөл: Ерөнхийлөгчийн сонгууль


Нэгдүгээр сарын 28



Эль Сальвадор

Сонгуулийн төрөл:
Ерөнхийлөгчийн сонгууль,
хууль тогтоох сонгууль

Хоёрдугаар сарын 04



Пакистан

Сонгуулийн төрөл: Бүх
нийтийн сонгууль, аймгийн
сонгууль

Хоёрдугаар сарын 08



Индонез

Сонгуулийн төрөл: Ерөнхий
сонгууль

Хоёрдугаар сарын 14



Сенегал

Сонгуулийн төрөл:
Ерөнхийлөгчийн сонгууль

Хоёрдугаар сарын 25



Беларусь

Сонгуулийн төрөл: УИХ-ын
сонгууль

Хоёрдугаар сарын 25



Камбож

Сонгуулийн төрөл: Сенатын
сонгууль

Хоёрдугаар сарын 25



Словак

Сонгуулийн төрөл:
Ерөнхийлөгчийн сонгууль

Гуравдугаар сар



Эль Сальвадор

Сонгуулийн төрөл: Хотын
болон ПАРЛАЦЕН-ийн
сонгууль

Гуравдугаар сарын 03

СҮДАЛГААНЫ САН

**Португал**

Сонгуулийн төрөл: УИХ-ын сонгууль

Гуравдугаар сарын 10

**Орос**

Сонгуулийн төрөл: Ерөнхийлөгчийн сонгууль

Гуравдугаар сарын 17

**Турк**

Сонгуулийн төрөл: Орон нутгийн сонгууль

Гуравдугаар сарын 31

**Энэтхэг**

Сонгуулийн төрөл: УИХ-ын сонгууль

Дөрөвдүгээр сар

**Бүгд Найрамдах Кирибати Улс**


Сонгуулийн төрөл: Ерөнхийлөгчийн сонгууль

Дөрөвдүгээр сар

**Соломоны арлууд**

Сонгуулийн төрөл: УИХ-ын сонгууль

Дөрөвдүгээр сар

**Өмнөд Солонгос**

Сонгуулийн төрөл: Үндэсний ассамблейн сонгууль

Дөрөвдүгээр сарын 10

**Өмнөд Африк**


Сонгуулийн төрөл: Ерөнхий сонгууль

Тавдугаар сар

**Их Британи**

Сонгуулийн төрөл: Орон нутгийн сонгууль

Тавдугаар сарын 02

**Панам**


Сонгуулийн төрөл: Ерөнхий сонгууль

Тавдугаар сарын 05

**Литва**

Сонгуулийн төрөл: Ерөнхийлөгчийн сонгууль

Тавдугаар сарын 12

**Доминиканы Бүгд Найрамдах Улс**

Сонгуулийн төрөл: Ерөнхий сонгууль

Тавдугаар сарын 19

**Ирланд**

Сонгуулийн төрөл: Орон нутгийн сонгууль

Зургаадугаар сар

**Хорват**

Сонгуулийн төрөл: УИХ-ын сонгууль

Зургаадугаар сар

**Исланд**

Сонгуулийн төрөл: Ерөнхийлөгчийн сонгууль

Зургаадугаар сарын 01

**Мексик**

Сонгуулийн төрөл: Ерөнхий сонгууль

Зургаадугаар сарын 02



Европын холбоо

Сонгуулийн төрөл: УИХ-ын сонгууль

Зургаадугаар сарын 06



Бельги

Сонгуулийн төрөл: Холбооны сонгууль, нутаг дэвсгэрийн сонгууль

Зургаадугаар сарын 09



Монгол

Сонгуулийн төрөл: УИХ-ын сонгууль

Зургаадугаар сарын 28



Австри

Сонгуулийн төрөл: Хууль тогтоох сонгууль

Есдүгээр сар



Босни ба Херцеговина

Сонгуулийн төрөл: Хотын сонгууль

Аравдугаар сарын 06



Бразил

Сонгуулийн төрөл: Хотын сонгууль (эхний шат)

Аравдугаар сарын 06



Мозамбик

Сонгуулийн төрөл: Ерөнхий сонгууль

Аравдугаар сарын 09



Литва

Сонгуулийн төрөл: УИХ-ын сонгууль

Аравдугаар сарын 13



Уругвай

Сонгуулийн төрөл: Ерөнхий сонгууль

Аравдугаар сарын 27



Румын

Сонгуулийн төрөл: Ерөнхийлөгчийн сонгууль


Арваннэгдүгээр сар



Америкийн Нэгдсэн Улс

Сонгуулийн төрөл: Ерөнхийлөгч, Төлөөлөгчдийн танхим, Сенат, Губернаторын сонгууль

Арваннэгдүгээр сар 05



Палау

Сонгуулийн төрөл: Ерөнхий сонгууль


Арваннэгдүгээр сар 12



Индонез

Сонгуулийн төрөл: Орон нутгийн сонгууль

Арваннэгдүгээр сар 27



Узбекистан

Сонгуулийн төрөл: УИХ-ын сонгууль

Арванхоёрдугаар сар



UIN.MN
СЭДЭГ ААНЫСАН



МОНГОЛ УЛСЫН СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРОО

Засгийн газрын 11 дүгээр байр
Ж.Самбуугийн гудамж,
Улаанбаатар – 15141, Монгол Улс

Санал хүсэлт хүлээн авах хаяг:
gecm@m-election.mn
(976) -51 262127

UIH.MN
СУДАЛГААНЫ САН